

HEED

Higher Education Discovery

Олон улсын сэтгүүл

НУУЦЛАГ ЯКУТ

УЛААНБААТАР ДАХЬ
РУССКИЙ ДОМ

ОРОСЫН ИХ ДЭЭД
СУРГУУЛИУДЫН
HEED ГАЗРЫН ЗУРАГ



ЗХХИС-ийн оюутны байранд үнэ
төлбөргүй амьдрах эрхийн бичиг
37-р хуудас дээр

ОРОС ТАНЫГ ХҮЛЭЭЖ БАЙНА

Элсэхдээ яаж давуу тал эдлэх вэ

ЗХХИС-Д ЭЛСЭЭРЭЙ



СВФУ



М. К. Аммосовын нэрэмжит Зүүн хойд
Холбооны их сургууль



6,7
10-Р САРЫН

Улаанбаатар
Русский Дом

Монгол дахь «Оросын үндэсний боловсролын үзэсгэлэн-2023»

Зохион байгуулагч

Россотрудничество-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар
Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Элчин
сайдын яамны дэмжлэгтэйгээр

☎ +976 11-45-46-00

☎ +976 99-26-26-12

✉ borisova.d@rcnkmn.ru



«Росотрудничество»-ийн
дэмжлэгтэйгээр

Агуулга

Оростой илүү дотно	6
Орос хэл – замнал ба мэргэжил	14
Мөрөөдөлдөө тэмүүлж, бууж өгөхгүй байх	18
Их сургууль бол хязгааргүй их боломжийн орон зай	22
Төслийн оролцогч их сургуулиудын НED газрын зураг	24
Оростой танилцах нь. Бүгд Найрамдах Саха (Якут) Улс	26
М. К. Аммосовын нэрэмжит Зүүн хойд Холбооны Их сургууль	36
Спортын гүүр Монгол – Якут	40
Арктикийн улсын соёл, урлагийн дээд сургууль	42
Чурапчагийн улсын биеийн тамир, спортын дээд сургууль	46
Бүгд Найрамдах Саха (Якут) Улсын Хөгжмийн дээд сургууль	50
Байгалийн улсын их сургууль	52
Доржи Банзаровын нэрэмжит Буриадын Улсын их сургууль	56
Вяткагийн улсын хөдөө аж ахуйн технологийн их сургууль	60
Газар зохион байгуулалтын улсын их сургууль	64
Москвагийн Улсын Технологийн Их Сургууль «СТАНКИН»	68
И. М. Губкины нэрэмжит Оросын газрын тос, байгалийн хийн улсын их сургууль (Үндэсний судалгааны их сургууль)	72
Санкт-Петербургийн улсын мал эмнэлгийн их сургууль	76
Их Петр хааны нэрэмжит Санкт-Петербургийн Политехникийн Улсын Их Сургууль	80
Өмнөд Уралын улсын их сургууль (үндэсний судалгааны их сургууль)	84

1 хавтас дээрх зургийг М. К. Аммосовын нэрэмжит Зүүн хойд Холбооны их сургууль сургалчилгааны эрхтэйгээр олгосон болно.

Өгсөн зургийн зохиогчийн эрхийг хангах ба илгээсэн материалын агуулгыг хариуцлагыг сурталчлагч хүлээнэ.

Энэ дугаарт

6

Улаанбаатар дахь
Русский Дом олон
тооны арга хэмжээ
зохион байгуулдаг.
Бид та бүхэнд Монголд
явагддаг хамгийн тод үйл
ажиллагааг танилцуулж
байна.



14

Нээлттэй, чин сэтгэлийн
түүхүүд олон асуултанд
хариулж, элсэгчдийн
эргэлзээ ба айдсыг
арилгахад тусалдаг.
Манай булангийн зочин –
Россотрудничество-
ийн Монгол дахь
төлөөлөгчийн газрын
орос хэлний арга зүйч
Нармандахын
Батцэцэг.

18

Олон төгсөгчид эх
орондоо буцаж очдог
бөгөөд ингэх нь тэдний
үүрэг, хариуцлага гэж
үздэг. Яагаад гэдгийг
Улаанбаатар хотын
Дуурь бүжгийн эрдмийн
театрын найруулагч
Мэндбаяр Баярдаваа
тайлбарлаж байна.



Бид WeChat-д



ID: HEDmagazine



22

Илүү ихийг мэдэж авах, илүү ихийг сурах, илүү сайн болох боломж хаа сайгүй байдаг. Тэднийг ашиглаж чаддаг байх, өөрийгөө ялан дийлэх зориг ба сонирхолтой байх нь чухал.

26

Якут, Якутын соёл, гайхамшигтай газрууд, сонирхолтой зүйлсийн талаар гайхалтай Бүгд Найрамдах Саха улсад зориулсан тоймоос уншина уу.



40

Шинэ орчинд нэвтрэх, өөр хэл сурах, олон төрлийн ур чадвар эзэмших, орчин үеийн мэдлэгтэй болох, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицох чадвар зэрэг нь хүчирхэг мэргэжилтэн ба чадварлаг боловсон хүчин бэлтгэдэг.

Найзууд аа!

Манай хамт олон энэ сэтгүүлийг сонирхолтой бөгөөд ашиг тустай байлгахын тулд маш их хичээж ажилласан. Бид хамтдаа сэтгүүлийг илүү сайн болгож чадна! Хэрэв та туршлагаа хуваалцах, ирээдүйн төлөвлөгөөний тухай ярих эсвэл сэтгэгдэл үлдээх хүсэлтэй байгаа бол цахим шуудангаар холбогдоорой [✉ dir@hedclub.com](mailto:dir@hedclub.com).

36



ЗХХИС

42



АУСУДС

46



ЧУБТСДС

50




БНСУ (Я) ХДС

52



БУИС

56



Доржи Банзаровын нэрэмжит БУИС

60




Вяткагийн УХААТИС

64




ГЗБУИС

68



«СТАНКИН» МУТИС

72



Губкины их сургууль

76



СПУМЭИС

80



СППУИС

84



ӨүруИС (УСИХ)





Оростой илүү дотно

«РУССКИЙ ДОМ»-ЫН (РЦНК) УЛААНБААТАР ЯВУУЛДАГ АРГА ХЭМЖЭЭНҮҮД



Орост ирээд энэ сайхан оронд дурлахгүй байхын аргагүй. Үүнийг Оросын их дээд сургуулийн гадаад оюутан бүр нотолно. Та Оросын Холбооны Улсад байхгүй байхдаа ч гэсэн зочломтгой уур амьсгалыг мэдэрч, Оросын уламжлалт баяр ёслолд оролцож, Оросын их дээд сургуульд элсэхийн тулд авьяас чадвараа харуулах боломжтой.

Улаанбаатар дахь «Русский Дом» (РЦНК) нь ийм төрлийн олон тооны арга хэмжээ зохион байгуулдаг бөгөөд эдгээр арга хэмжээнд оролцох нь таныг Оросыг өөрийн нүдээр харах ба Оросын их сургуулийн оюутан болох том мөрөөдөлд тань урам зориг өгөх болно. Бид та бүхэнд Монголд болдог хамгийн тод, сонирхолтой ба зугаатай арга хэмжээнүүдийг танилцуулж байна.

«ПОЕХАЛИ!» ОДДЫН ЦЭЭЖ БИЧИГ

Жил бүрийн 4-р сард Монгол улс болон дэлхийн бусад улс орнуудад «Поехали!» оддын цээж бичиг хэмээх «Россотрудничество»-ийн нийгэм, соёлын төсөл зохион байгуулагддаг! Анх удаа энэхүү хүмүүнлэгийн арга хэмжээг 2021 онд Юрий Гагарины сансарт ниссэний 60 жилийн ойн баяраар зохион байгуулсан юм. Үүнд 45 орны 17 000 гаруй хүн оролцсон. 2022 онд 62 орны 24 000 хүн Оддын цээж бичгийг бичсэн. 2022 оноос эхлэн тус онлайн цээж бичгийг «Циолковский» кино ба сансрын тухай нэвтрүүлгийн Олон улсын кино наадмын хүрээнд явуулдаг болсон. Энэ жил цээж бичгийн бичвэрийг Оросын зохиолч, сэтгүүлч, сансрын түүхч, сансрын тухай маш сонирхолтой шинжлэх ухааны уран зөгнөлт, шинжлэх ухааны олон нийтэд зориулсан бүтээлүүдийн зохиолч Антон Первушин зохиосон юм.

Тус арга хэмжээнд нас, боловсрол, оршин суугаа газраас үл хамааран хүн бүр оролцох боломжтой. Хамгийн гол нь сансар судлалын үйл явдлуудтай холбоотой түүхэн үйл явдлуудыг эргэн дурсаж, авьяаслаг залуусыг илрүүлэх явдал юм.

Тусгай маягтаар оролцогчид зөв үг ба хэллэгийг тэмдэглэдэг. Гадаадын улс оронд цээж бичиг бичиж буй хүмүүст зориулж сайт дээр  араб,  хятад,  герман,  франц эсвэл  англи хэлийг сонгох боломжтой байдаг.

Бүртгүүлээд, оролцоод, шагналын эзэн болоорой!



ОРОС ХЭЛНИЙ СУРГАЛТ

Улаанбаатар дахь «Русский Дом» (РЦНК) нь нас ба боловсролын түвшингээс үл хамааран хүн бүрт зориулагдсан орос хэлний төлбөртэй сургалтууд зохион байгуулдаг.

Хоёр сарын эрчимжүүлсэн сургалт эсвэл нэг жилийн сургалт сонгох боломжтой. Дунд сургуулийн төгсөгчдөд зориулсан тусгай өдрийн ангийн сургалт бас байдаг.



“

Нармандах Батцэцэг, багш, нээлттэй боловсролын хүрээлэнгийн арга зүйч

Манай сурагчдын ихэнх нь цаашид оросын боловсрол эзэмших зорилготойгоор орос хэлийг эхнээс нь сурч байгаа монгол сургуулийн ахлах ангийн сурагчид байдаг. Ажил хийдэг залуучууд орос компаниудтай хамтран ажиллахын тулд манай сургалтанд хамрагддаг.

Орос хэлний сургалтын сурагчдын дунд уламжлал болсон хаврын спартакиадыг зохион байгуулдаг. Энэ оны гуравдугаар сард тус спортын арга хэмжээ нь Зөвлөлт Холбоот Улсын Маршал ба хошой баатрын цолтой Исса Плиевын нэрэмжит 49-р дунд сургуульд явагдсан. Охид, хөвгүүд сагсан бөмбөг ба гар бөмбөгийн төрлөөр өрсөлдсөн.

Түрүүлсэн багууд диплом болон дурсгалын медалиар шагнуулсан, харин шавь нараа дэмжихээр ирсэн багш нар амралтын өдрийн эрч хүч авах ба сурагчдаараа бахархах урамшуулал хүртсэн юм!



“

Валерия Кильпякова, Улаанбаатар дахь «Русский Дом»-ын (РЦНК) даргын үүрэг гүйцэтгэгч

Манай хүүхдүүд орос хэлийг идэвхтэй судлахаас гадна спортоор идэвхтэй хичээллэдэг нь их сайн хэрэг, учир нь биеийн эрүүл мэнд нь сайн сайхан байдал, сайн мэдлэгийн үндэс болдог. Эрүүл биед саруул ухаан оршино гэдэг шүү дээ.



Улаанбаатар дахь «Русский Дом»-д (РЦНК) найман уран бүтээлийн холбоо байнгын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хоёр улсын иргэд уран зураг, дуу, театр, бүжиг дэглэлтийн чиглэлээр хичээллэдэг юм. Олимпиад, Оросын их дээд сургуулиудын төлөөлөгчдийн уулзалт, Оросын их дээд сургуульд элсэх сонгон шалгаруулалтын ярилцлага болон бусад арга хэмжээ зохион байгуулагддаг.



«РУССКАЯ МЕЛОДИЯ» ДУУНЫ УРАЛДААН

Уран бүтээлийн уралдаан тэмцээнд монгол залуус оролцох маш их сонирхолтой байдаг. “Русская мелодия” уламжлалт дууны уралдаанд (Багануур хот) энэ онд 100 гаруй хүн оролцсон.

Улаанбаатар дахь «Русский дом»-ын (РЦНК) ажилтнуудыг багтаасан хатуу шүүгчдийн бүрэлдэхүүн нь бүх насны оролцогчдыг гоцлол дуу, найрал дуу, чуулга дуу хэмээх төрлүүдээр үнэлсэн. Цагдаа, инженер, цахилгаанчин, цэргийн алба хаагч, сурган хүмүүжүүлэгч, оюутнууд, мэдээжийн хэрэг орос хэлний багш зэрэг төрөл бүрийн мэргэжлээр ажилладаг оролцогчид дууны чадвараараа шүүгчдийг гайхшруулсан.

Уралдаан хоёр үе шаттай явагдсан: сонгон шалгаруулах үе шатанд хамгийн олон оноо авсан оролцогчид финалын шатанд шалгарсан. Дараа нь насны ангилал бүрт гурав гурван шагналын байрыг тодруулсан. “Русская мелодия” дууны уралдааны ялагчдад тус арга хэмжээний зохион байгуулагч ба түнш байгууллагуудаас өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйлсийг шагнаж урамшуулсан. «Русский Дом»-ын (РЦНК) нь уралдааны хамгийн бяцхан ялагчид болон орос хэлний залуу багш нарт зориулж номын бэлэг бэлдсэн.



«ШИРОКАЯ МАСЛЕНИЦА» БУЮУ «ШАР ТОСНЫ БАЯР»

Шар тосны баярыг Улаанбаатар хотод маш хөгжилтэй бөгөөд өргөн цар хүрээтэй тэмдэглэдэг. Энэ жил Оросын уламжлалт баяраар мянга орчим хүн «Русский Дом»-д (РЦНК) хүрэлцэн ирсэн юм.

Энэхүү ардын баярыг Орост өвлийн улирлын төгсгөлд тэмдэглэдэг уламжлалтай бөгөөд энэ нь хаврын эхэн үеийн бэлэгдэл болдог. Олон зуун жилийн уламжлалын дагуу өвлийн улирлыг өргөн дэлгэр баярлан үдэж, зочдыг амттангаар дайлж, цаг хугацааг хөгжилтэй өнгөрүүлдэг заншилтай.

Улаанбаатар хотын «Русский Дом»-д (РЦНК) энэхүү баяр нь сайхан уламжлал болоод удаж байгаа, гэхдээ цар тахлын улмаас хэдэн жил дараалан зохион байгуулагдаагүй юм. Энэ жил арга хэмжээ нь Монголын үндэсний баярын өдрүүдтэй давхцсан.

Үзэгчид хөгжим, бүжиг дэглээч үзүүлбэр үзэн хөгжилдөж, дуулж, бүжиглэж, тостой шон руу авирч, олон төрлийн тоглоом, зугаа цэнгэл, уралдаан тэмцээнд оролцож, блинчик идэж, дугуй бүжиг бүжиглэжээ.

Баярын удаан хүлээсэн оргил үе нь «Широкая Масленица» сугалааны хожлын тохирол байлаа. Арга хэмжээний оролцогчдын дунд Оросын их, дээд сургуулиуд, Улаанбаатар дахь «Русский Дом» (РЦНК) болон Аэрофлот, Газпромбанк, Монретранс, «Сезам» зөв хооллолтын үйлдвэр, FIX PRICE дэлгүүр зэрэг «Россотрудничество»-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын түнш байгууллагуудаас 30 шагналтай сугалааны хожлын тохирол явагдсан юм.

ТҮҮХ СОНИРХОГЧДЫН КЛУБ

2023 оны хавар Монгол дахь «Россотрудничество»-ийн талбайд «Түүх сонирхогчдын клуб» нээгдсэн. Орос-Монголын хамтын түүхийг судлахаар монгол залуучууд, Орос ба Монголын түүхчид, оросын ТББ-уудын төлөөлөгчид нэгдсэн юм.



Даваажав Баяртогтох, «Түүх сонирхогчдын клуб»-ын удирдагч, түүхийн шинжлэх ухааны доктор

Манай клубын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Орос Монголын хамтын ажиллагаатай холбоотой сэдвүүдийг судлахад оршдог. Манай хоёр улс нөхөрлөлийн олон арван жилийн түүхтэй, орос ба монголчуудын харилцааны түүхэнд олон тооны сонирхолтой баримтууд байдаг, гэвч харамсалтай нь ихэнх залуучууд үүний тухай мэддэггүй. Хүмүүс түүхээ мэддэг байх ёстой, учир нь түүх бол манай хоёр улсын ард түмнүүдийн амьдралын салшгүй хэсэг юм.

Орос-Монголын хамтын ажиллагааны түүхэн үйл явдлуудыг сонирхдог бүх хүмүүсийг манай клубт элсэхийг урьж байна. Манай клубын хаалга хүн бүрт нээлттэй байдаг, манай уулзалт сар тутам «Русский Дом»-д (РЦНК) явагддаг. Манай үйл ажиллагааны зарлалыг хараарай.



«ЭХ ОРНЫХОО ТУХАЙ ДЭЛХИЙД ЯРЬ» ОЛОН УЛСЫН УРАЛДААН


Монголын дунд сургуулийн сурагчид «Эх орныхоо тухай дэлхийд ярь» олон улсын 5-р уралдаанд идэвхтэй оролцлоо.

Монголын түүхэн дурсгалт газар, аялал жуулчлалын объект, үзэсгэлэнт газруудын тухай 17 бүтээл тус арга хэмжээний чимэг болсон гэж арга хэмжээний зохион байгуулагчид онцолсон юм.

«Хүүхэд залуучуудын хөгжил, хүмүүжлийн дэвшилтэт төв» бие даасан ашгийн бус байгууллага нь Оросын Төрийн Думын Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдийн асуудал эрхэлсэн хороотой хамтран «Россотрудничество»-ийн дэмжлэгтэйгээр 2023 оны хавар тус уралдааны эхлэлийг зарласан. Монгол хүүхдүүд энэ төсөлд маш хурдан хамрагдаж оролцсон.

Тус уралдааны нөхцөлийн дагуу дэлхийн өөр өөр улс орны хүүхэд залуучууд эх орныхоо амьдралын хамгийн сонирхолтой мөчүүдийг сонгон авч, тэднийг видео бичлэг эсвэл танилцуулгын хэлбэрээр ярих ёстой байсан юм. Жил бүр тус уралдааны оролцогчдын бүтээлүүд интернетэд нийтлэгдэж, Оросын болон гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр, мөн улсын болон олон нийтийн томоохон платформуудаар цацагддаг.

«Эх орныхоо тухай дэлхийд ярь» уралдаан зохион байгуулагдсан нийт хугацааны турш уралдааны оролцогчид Оросын 89 бүс нутаг болон гадаадын 52 улс орноос 10 000 орчим бүтээл ирүүлсэн байна. Тав дахь уралдаанд **Орос, Киргиз, Беларусь, Монгол, Казахстан, Молдав, Узбекистан, Ливан, Вьетнам** зэрэг 35 улсын төлөөлөгчид оролцсон.



Монгол хүүхдүүд Эх орныхоо тухай юу ярьсан бэ? Жишээлбэл, Хадбаатар Гантулга 15-аас дээш насны ангиллын «Видео бичлэг»-ийн бүтээл ирүүлсэн. Түүнд тэрээр «13-р зуун» үндэсний цогцолборын талаар ярьсан. Чинбат Эрхэмбаяр Цонжинболдог дахь Чингис хааны морьт хөшөөг танилцуулж, түүний хэмжээ, бэлэгдэл ба байршлын тухай ярьсан.

«Эх орныхоо тухай дэлхийд ярь» уралдааны бусад оролцогчдын бүтээлүүд



ЭРХҮҮ ХОТЫН ОДОН ОРОН СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ХАМТ ОДОН ОРОН СУДЛАЛЫН АЖИГЛАЛТ

2023 оны 3-р сард Эрхүү хотын одон орон судлалын хүрээлэн Улаанбаатар хотод дахин ирж, хотын оршин суугчдад зориулсан боловсролын аяны ажил хийж явуулсан. «Россотрудничество»-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар болон Оросын одон орон судлаачдын ачаар оддыг задгай тэнгэрт ажиглах боломжтой байсан.

Дөрвөн өдрийн турш хүссэн хүн бүр өсөн томорч буй Сар, Сугар, Ангараг гараг болон хос оддыг хамгийн их ойртуулсан хэмжээгээр харж чадсан юм.



“

Павел Никифоров, Эрхүү хотын одон орон судлалын хүрээлэнгийн захирал (Орос, Эрхүү муж, Эрхүү хот)

Бид “Азийн хаалга” олон улсын үзэсгэлэнд хоёр дахь удаагаа оролцож байгаа бөгөөд энэ жил хүссэн хүн бүрт оддын одон орны ажиглалт хийлгэж үзүүлэхийн тулд Монголд дахин дурантайгаа ирсэн.

Улаанбаатарын тэнгэр үргэлж үзэсгэлэнтэй байдаг, харин хотоос гараад улам гоё болдог – гудамжны гэрэлтүүлэг, хиймэл гэрэлгүй болдог учраас үргэлж олон одод харагддаг. Энэ удаад цаг агаарын байдал их сайхан байсан тул Сар, Сугар, Ангараг гаригийн ажиглалт онцгой сонирхолтой болсон. Мэдээжийн хэрэг 3-р сарын 24-ний үдэш Сугар гараг Сартай маш ойртох үед хийсэн ажиглалтууд хамгийн гайхалтай байсан. Энэ нь одон орон судлалын хувьд ховор тохиолддог үзэгдэл бөгөөд бид үүнийг монгол хүмүүст харуулж чадсандаа баяртай байна.





«АРТЕКИЙН ХҮМҮҮС» ОЛОН УЛСЫН УРАЛДААН

Хамгийн идэвхтэй бөгөөд сониуч хүүхдүүд олон хүүхдүүдийн мөрөөдөл болсон «Артек» зуслан руу явах боломжтой. Энэ гайхалтай боломжийг авахын тулд өөрийн амжилтуудыг заасан хүсэлт бөглөхөөс гадна бас нэг арга бий – судалгааны уралдаан оролцох.

«Артек»-ийн зуун жилийн ойг тохиолдуулан «Артекийн хүмүүс» хэмээх олон улсын судалгааны уралдаан зохион байгуулагдаж байна. Сургуулийн сурагчид өмнөх жилүүдийн Артекийн хүмүүсийн тухай мэдээлэл цуглуулж, тэдний амьдралын замнал, ололт амжилтын талаар олж мэддэг.

Тус уралдаанд гадаадын 29 орны 12-17 настай сурагчид, мөн Монголд байнга оршин суудаг эх орон нэгт орос хүүхдүүд оролцох боломжтой. Уралдааны ялагчид «Артек»-ийн 8-р зуны ээлжээр үнэ төлбөргүй амрах эрхтэй болно.



Константин Федоренко, «Артек» ОУХТ-ийн захирал

«Артек» бол бараг нэг зуун жилийн түүхтэй олон улсын хүүхдийн төв юм. Манай төв нь үйл ажиллагаа явуулсан нийт хугацааныхаа туршид дор хаяж нэг удаа ирж байсан хүмүүсийн амьдралд арилшгүй ул мөр үлдээгээд зогсохгүй сурагчдынхаа ирээдүйн амьдралд томоохон нөлөө үзүүлдэг.

Улаанбаатар дахь «Русский Дом»-ийн (РЦНК) албан ёсны хуудсуудаас илүү их арга хэмжээний тухай мэдээлэлтэй танилцах боломжтой.





Орос хэл – замнал ба мэргэжил

Мэргэжлээ сонгоход суралцах чиглэл, их сургууль, суралцах улс гэх мэт олон тооны сонголт хийх хэрэгтэй байдаг. Ихэвчлэн мэргэжлийн сонголтыг тухайн хүний сонирхол, хандлага, хувийн зан чанар, хувь хүний төлөв байдал нь тодорхойлдог. Харин суралцах их сургууль ба улсыг сонгоход хүрээлэн буй орчин, юуны өмнө гэр бүл ба найз нөхөд, мөн эх орон нэгтнүүдийн урам зориг өгсөн жишээ нөлөөлдөг. Тиймээс бид Оросын их дээд сургуулийн төгсөгчдөд Оросд суралцсан туршлага ба мэргэжлийн замналын сонголтын талаар асуултууд тавьж хандсан юм.

Нээлттэй, чин сэтгэлээсээ хуваалцсан түүхүүд олон тооны асуултад хариулж, элсэгчдийн эргэлзээ ба айдсыг арилгахад тусална гэдэгт HED сэтгүүлийн редакторууд итгэлтэй байна. Өнөөдөр манай булангийн зочин нь «Россотрудничество»-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын орос хэлний арга зүйч Батцэцэг Нармандах юм.



**Батцэцэг
Нармандах**

МЭРГЭЖЛИЙН ХУВЬД ӨӨРИЙГӨӨ ТОДОРХОЙЛОХ ТУХАЙ

Миний мэргэжлийн сонголтод орос хэлний багш мэргэжилтэй ээж маань чухал нөлөө үзүүлсэн. Миний аав ээж хоёр ЗХУ-д, тухайлбал аав Москва хотод, ээж Свердловск (Екатеринбург) хотод суралцаж, дээд боловсрол эзэмшсэн тул миний хувьд суралцах улсыг сонгоход бүх зүйл тодорхой байсан. 9-р ангиасаа эхлээд би орос хэлний улсын олимпиадад бэлдэж, 10-р ангидаа 3-р байр эзэлсэн. Энэ нь надад Оросын их дээд сургуульд үнэ төлбөргүй суралцах эрх олгосон. Хуваарилалтаар би М. Горькийн нэрэмжит Уралын Улсын их сургуулийн (одоо УрФУ) филологийн тэнхимийн (Орос хэл, уран зохиолын чиглэл) оюутан болсон.

реша выбора
(решаю - 1 сур)

ДАСАН ЗОХИЦОЛ БА СУРГАЛТЫН ТУХАЙ

Би их сургуулийн өмнөх бэлтгэл ангид суралцаагүй, тухайн үед бид шууд 1-р дамжаанд суралцаж эхэлсэн. Тиймээс шинэ улсад очоод, шинэ бодит байдалд орох нь эхэндээ бага зэрэг хүндрэлтэй байсан. Би оюутан найзууддаа талархаж явдаг, тэд их сургуульд элссэн эхний өдрөөс эхлээд миний амьдралд шууд ороод ирсэн. Тэдний ачаар миний хувьд дасан зохицоход маш "амар" байсан.

- учис. (-ious-)

Сургалтын үйл явцын хувьд тийм ч амархан байгаагүй. Орос хэлний анхан шатны мэдлэгтэй гадаад хүний хувьд филологийн тэнхимийн 1-р дамжаа бол "хүч" сорьсон чухал сорилт байсан 😊. Уран зохиол, орос хэл, хуучин славян хэл, гадаад хэл, мөн филологийн удиртгал, ерөнхий хэл шинжлэл, уран зохиолын онол зэрэг олон тооны ерөнхий филологийн хичээлүүд нь сургалтын материалд маш их анхаарч, ойлгохыг шаардсан. Тухайн үед надад их хэцүү байсан 😊.

Рагу м А В И

Хүндрэл бэрхшээлтэй байсан ч гэсэн би энэ замыг туулж, сайн боловсрол эзэмшсэндээ их баяртай байдаг. Гайхамшигтай багш ба найз нөхдийн дэмжлэггүйгээр би үүнийг хийж чадахгүй байх байсан.

МЭРГЭЖЛИЙН АЖЛЫН ТУХАЙ

Бакалаврын зэрэгтэй болсны дараа би магистрын ангид үргэлжлүүлэн суралцсан. 2010 оны 12-р сараас өнөөдрийг хүртэл би Улаанбаатар дахь «Русский Дом»-д (РЦНК) ажиллаж байна.

Миний мэргэжлийн замнал орос хэлийг гадаад хэл болгон (РКИ) заах ажлаас эхэлсэн. Орос хэлийг гадаад хэл болгон заах арга зүй нь орос хэлийг төрөлх хэл болгон заах арга зүйгээс ялгаатай байдаг. Орос хэлийг гадаад хэл болгон заах онол ба практик эзэмшсэнээр би өөрийн мэдлэгийн энэ дутагдлыг бие дааж нөхсөн. Ингэхэд надад манай багш нарын суулгасан боловсрол ба хэл судлалын дотоод чадвар тус болсон.

Ямар ч багшийн ажил нь өөрийгөө байнга хөгжүүлж, сайжруулахыг шаарддаг гэдэгт би итгэлтэй байдаг. Тийм учраас боловсролын салбарт ажиллаж буй мэргэжилтний хувьд шинэ ур чадвар ба мэдлэг эзэмших нь мэргэжлийн түвшинг тодорхойлох зайлшгүй шаардлага болдог.

Весточка





ОРОС ХЭЛ БА «РУССКИЙ ДОМ»-ЫН (РЦНК) ТУХАЙ

Өнөөдөр Улаанбаатар дахь "Русский Дом"-ын дэргэд орос хэл сурах хүсэлтэй хүмүүст зориулсан олон төрлийн хөтөлбөрүүдийг санал болгодог Орос хэлний төв үйл ажиллагаа явуулдаг: 12-р ангийн сурагчдад зориулсан нэг жилийн өглөөний сургалт ба нэг жилийн өдрийн сургалт. Ихэвчлэн нэг жилийн сургалт нь Оросын их дээд сургуульд үргэлжлүүлэн дээд боловсрол эзэмшихээр төлөвлөж буй хүмүүст зориулагдсан байдаг. Зуны улиралд бид Орос улсыг зорьж буй ба хичээлийн эсвэл ажлын чөлөөт цагаараа орос хэлний мэдлэгээ цэнэглэж, Оросын соёлтой танилцах хүсэлтэй хүмүүст зориулсан эрчимжүүлсэн сургалтын хөтөлбөрийг санал болгодог.

Ерөнхийдөө бол "Русский дом"-ын үйл ажиллагаа нь зөвхөн орос хэлний сургалтаар хязгаарлагддаггүй. Бид бүх хүмүүст зориулсан төрөл бүрийн сэдэв бүхий олон тооны арга хэмжээ зохион байгуулдаг. Манай талбарууд дээр 8 уран бүтээлийн холбоо (бүжгийн, урлагийн, дууны ба театрын) ажилладаг. Эдгээр холбоодын удирдагчдын ихэнх нь Оросын их дээд сургуулиудын төгсөгчид байдаг. Пүрэв гараг бүр РД-ын жижиг танхимд үнэ төлбөргүй орос кино үзүүлдэг. "Русский Дом"-ын үйл ажиллагааны тухай мэдээллийг Монголд их түгээмэл Facebook* сошиал сүлжээн дэх манай албан ёсны хуудаснаас харах боломжтой. Тавтай морил!

*Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрт хэт даврагч байгууллага гэж тогтоогдсон

Handwritten text in Cyrillic: *Их сургуульд зориулсан сургалтын төв*

Handwritten letter: **Н**

Handwritten text in Cyrillic: **БИЙ**

Handwritten text in Cyrillic: **МН**

Handwritten text in Cyrillic: **ТД**

Handwritten text in Cyrillic: **ТД**

Handwritten text in Cyrillic: **ТД**

Handwritten text in Cyrillic: **ТД**



Мөрөөдөлдөө тэмүүлж, бууж өгөхгүй байх

Оросын их дээд сургуулийн гадаад төгсөгчдийн амьдрал хэрхэн өрнөж байгааг харах их сонирхолтой байдаг. Хүн бүр өөрийн гэсэн замаа сонгодог. Манай булангийн ихэнх баатрууд эх орондоо буцахыг сонгож, энэ нь тэдний амьдралын зам гэж хардаг. Ийм түүхүүд амьдралын философи ба дэлхий ертөнцийг илүү сайхан болгох хүсэл тэмүүллээр дүүрэн байдаг.

Төгсөгчдийн хойч үеийнхэнд ийм урам өгсөн жишээ нь Улаанбаатар хотын Дуурь бүжгийн эрдмийн театрын найруулагч Баярдаваагийн Мэндбаярын түүх байж болно.



Мэндбаяр Баярдаваа



МӨРӨӨДЛИЙН ХҮЧИЙН ТУХАЙ


Би хүүхэд байхаасаа Орост суралцахыг мөрөөддөг байсан. Гэхдээ миний энэ мөрөөдөлдөө хүрэх зам богино ба хялбар байгаагүй. Миний театрын их сургуульд элсэх түүх 2011 онд эхэлсэн. Тухайн үед би Монгол Улсын консерваторид суралцаж байсан бөгөөд энэ нь миний анхны оролдлого байсан. Харамсалтай нь энэ оролдлого бүтэлгүйтсэн. Консерваторийг төгсөөд Дуурь бүжгийн эрдмийн театрт дөрөв гаруй жил жүжигчнээр ажилласны дараа би хуучны мөрөөдлөө санасан.

2014 онд би найруулагч болох хүсэлтэй байгаагаа ойлгосон. Би элсэлт ба суралцах боломжит хувилбаруудын тухай мэдээллийг судалж эхэлсэн боловч ... харамсалтай нь элсэлтээс хоцорсон байсан. Ингээд би хоёр дахь боломжоо алдсан.

Нэг жилийн дараа би Оросын шинжлэх ухаан, соёлын төвд орос хэл дахин сурахаар очсон. Тухайн үед хэлний дүрэм болон харилцан яриа хөгжүүлэх хичээлийн хооронд орос хэлний багштайгаа би мөрөөдлийнхөө талаар ярилцсан. Ингээд миний гурав дахь оролдлогоо хийх цаг ирсэн. Нэг жил идэвхтэй хэл сурсны дараа би ГИТИС-д элсэхээр явсан.

Тэр удаа Москва явахад надтай нэгэн хөгжилтэй түүх тохиолдсон. Намайг тосох ёстой байсан найз маань намайг ирэхийг огт мартчихсан байсан. Би том хотод ганцаараа хүнд ачаатай үлдсэн. Тэр үед би төөрөлдөж, үнэхээр их айсан. Хачирхалтай нь тэр өдөр миний огт танихгүй монгол хүн надад тусалсан.

Тухайн үеийг би маш их талархалтайгаар дурсдаг. Оросын нийслэлд өнгөрүүлсэн 11 хоногийн хугацаанд би маш их сэтгэгдэл цуглуулсан. Тэгээд энэ удаад би зорилгодоо хүрч чадсан. Шалгалтаа амжилттай өгөөд, хичээлийн жил эхлэхэд тайван бэлдэхийн тулд буцаад Монгол явсан.



ГИТИС БА ОРОСЫН ТУХАЙ


Хичээлийн жил эхэлснээр надад амаргүй байх нь тодорхой болсон. Би хичнээн их хичээж, бэлдэж байсан ч гэсэн суралцахад хэцүү байсан. Бидний оюутны өдөр өглөөний 09:00 цагаас оройн 23:00 цаг хүртэл үргэлжилдэг байсан. Гадаад оюутан байсан миний хувьд орос хэл хамгийн хэцүү хичээл ба сорилт хэвээр байсан гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Орос хэл бол гоёмсог хэл боловч үүний зэрэгцээ сурахад маш хэцүү хэл бөгөөд өдөр бүр миний хүчийг сорьдог байсан. Надад тэвчээртэй хандаж, хэл сурахад минь дэмжлэг үзүүлж, тусалж байсанд би ангийнхандаа маш их талархдаг. Би тэдэнгүйгээр хэл сурч чадахгүй байх байсан нь лавтай.

Хичнээн хүндрэл бэрхшээлтэй байсан ч гэсэн ГИТИС-д өнгөрүүлсэн цаг хугацаа миний хувьд маш их аз жаргалтай үе байсан.

Би мэргэжлээ эзэмших хүсэл дүүрэн байсан. Би энэ зорилгодоо хүрэхэд хамгийн тохиромжтой газар байсан. Монголд ердөө нэг дуурийн театр, нэг драмын театр байдаг. Энэ утгаараа асар том театруудтай Москва хот монгол оюутанд эцэс төгсгөлгүй урам зориг өгдөг байсан.

Миний амьдралын энэ цаг үетэй холбоотой бас нэгэн гайхалтай дурсамж бий. Сургалтын эхний жил манай ангийнхан надад Монгол руу яваад буцаж ирэх тасалбар бэлэглэсэн. Энэ нь шинэ жилийн гэнэтийн бэлэг байсан. Энэ бол үнэхээр гайхамшигтай мөч байсан, учир нь тэр шинэ жил аавтай минь өнгөрүүлсэн сүүлийн шинэ жил байсан. Исаакянчуудын* гайхалтай ангийнхны тухай энэ халуун дурсамжийг би амьдралынхаа туршид өөртөө авч явдаг. ❤️

*Исаакянчууд – Георгий Георгиевич Исаакяны ангийн оюутнууд





элсэгчдэд өгөх зөвлөгөө

Орост суралцахаар төлөвлөж буй хүмүүст би дараах зөвлөгөө өгмөөр байна:

- 1 Орос хэл сур. Хэлний мэдлэг нь таны давуу тал ба таны туслах болно.
- 2 Яг сурахыг хүсч байгаа зүйлээ судал. Мэргэжил эзэмших чин хүсэл нь хүнд хэцүү үед маш их урам зориг өгдөг.
- 3 Мэргэжил/хот/их сургуулиа нухацтай сонго.
- 4 Бүх зүйл бүтэхгүй байсан ч гэсэн битгийг бууж өг. Энэ заавал өнгөрөх болно.
- 5 Ном унш. Ном мэдлэгийн цоорхойг нөхөхөд тусална.

МЭРГЭЖЛИЙН КАРЬЕР БА ЗАМНАЛЫН ТУХАЙ

ГИТИС-д суралцах эхний жилдээ би Москвад үлдэж, Орост мэргэжлийн карьераа үргэлжлүүлэх хүсэлтэй байсан. Харин дараа нь би Монголд буцаж ирээд, театрын урлагийг энд хөгжүүлэх ёстой гэдгийг ойлгосон. Яг ийм болж таарсан.



Улаанбаатар хотын Дуурь бүжгийн эрдмийн театрт би шинэ статустайгаар буцаж ирсэн. Одоо би театрын найруулагч болсон. Соёлын сонирхолтой төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг надад олгодог театрын удирдлага ба намайг дэмжиж, бүтээлч харилцаатай байдаг "Русский Дом"-д (РЦНК) би талархаж байна. Бидэнд бахархах зүйлс байгаа бөгөөд цаашид хийх зүйл ч бас их байна.

Их сургууль бол хязгааргүй их боломжийн орон зай



Давыд Мөнгөншагай, ерөнхий менежер, Доржи Банзаровын нэрэмжит Буриадын Улсын их сургуулийн Дорно дахины хүрээлэнгийн Эдийн засаг, удирдлагын сургуулийн төгсөгч



Бид мэргэжлийн замналаа дөнгөж төлөвлөж буй хүмүүст хэрэгтэй мэдээллийн эх сурвалж болж болох Оросын их дээд сургуулиудын гадаад төгсөгчдийн түүхийг уншигчиддаа үргэлжлүүлэн танилцуулсаар байна. Манай булангийн өнөөдрийн зочин бол Доржи Банзаровын нэрэмжит Буриадын Улсын их сургуулийн Дорно дахины хүрээлэнгийн Эдийн засаг, удирдлагын сургуулийн төгсөгч Давыд Мөнгөншагай юм.



Монголд гадаадын хөрөнгө оруулалттай компанийн ерөнхий менежерээр ажиллах амжилтын эхлэл нь Буриадын Улсын их сургуульд суралцсан явдалтай шууд холбоотой гэж би боддог. **БУИС-ийн ахлах курсын оюутнууд давхар мэргэжлээр суралцах боломжтой байдаг.** Өдрийн ангид суралцдаг оюутнууд энэ боломжийг ашиглах боломжтой.

Суралцах байх үедээ би үе тэнгийнхнээсээ хоцорч байгаагаа мэдэрч, илүү ихийг сурч, илүү хурдан хөгжих ёстой гэдгээ ойлгосон. Давхар мэргэжлээр суралцах боломж надад нээгдсэн талаар бодож байгаад би энэ бол маш гайхалтай боломж гэсэн дүгнэлтэд хүрсэн. Ингэснээр би ирээдүйд их сургуулиа төгсөхдөө нэмэлт давуу талтай болж чадна.

Хэлсэн бол хийх хэрэгтэй. Эдийн засаг, удирдлагын сургуульд төрийн болон орон нутгийн удирдлагын мэргэжлээр өдрийн ангид суралцаж байхдаа би давхар Хууль зүйн тэнхимд эчнээгээр суралцаж байсан. Ийнхүү би хоёр мэргэжлийг амжилттай зэрэг эзэмшиж, чадварлаг бөгөөд идэвхтэй оюутан болж чадсан юм.

Би олон улсын харилцаа болон бүс нутаг судлалын чиглэлээр Орос, Монгол, Хятадын шинжлэх ухааны ном зохиол унших дуртай. Би их сургуулийн шинжлэх ухаан, нийгэм, соёл урлаг, уран бүтээлийн амьдралд идэвхтэй оролцдог байсан. Оюутны амьдралын энэ үе шат бол миний мэргэжилтний хувьд төлөвшихөд хамгийн чухал үеийн нэг байсан гэж би боддог.


Тухайн үед би бүс нутаг ба бүх Оросын хэмжээний оюутны болон эрдэм шинжилгээний бага хурлуудад оролцож, Монгол Улс ба Бүгд Найрамдах Буриад улсад зохион байгуулагддаг олон улсын болон бүс нутгийн тэмцээний ялагч болж байсан. Үүнээс гадна, Монголын их дээд сургуулиудын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулахад тусалдаг байсан.

Буриадын Улсын их сургуулийн гадаад оюутнуудыг дэмжих тогтолцоо нь тэднийг сургалтын үйл явцад идэвхтэй оролцоход хувь нэмэр оруулж, илүү сайн суралцах, илүү ихийг мэдэж авахад нь түлхэц өгдөг. Хамгийн амжилттай оюутнууд улсын төсвийн зардлаар магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах боломжтой.

Шинжлэх ухааны чиглэлээр хөгжих хүсэлтэй хүмүүст аспирантурын үүд хаалга нээлттэй байдаг. Одоогийн байдлаар би дэд профессор, улс төрийн шинжлэх ухааны доктор Владимир Александрович Родионовын удирдлаган дор "Улс төр судлал, бүс нутаг судлал" мэргэжлээр аспирантурын 3-р курст суралцаж байна.


Би Доржи Банзаровын нэрэмжит Буриадын улсын их сургуульд талархаж байна, энэ сургууль бол миний хоёр дахь гэр гэж би хэлж чадна. Ирээдүй, мэргэжил, их сургуулиа сонгох гэж буй бүх хүмүүст би итгэлтэйгээр ингэж хэлж чадна: **Буриадын Улсын их сургууль таныг чадварлаг мэргэжилтэн, мэргэжлийн хүн болоход тусална!**

Төслийн оролцогч их сургуулиудын НЭД газрын зураг



■ ОХУ-ын шинэ бүс нутгууд: Бүгд Найрамдах Донецк ба Луганск Ард улс, Запорожье ба Херсон муж (04.10.2022-ны Холбооны Үндсэн хуулийн хуулиуд №5-ФКЗ, №6-ФКЗ, №7-ФКЗ, №8-ФКЗ)

- Төв Холбооны тойрог
- Баруун хойд холбооны тойрог
- Өмнөд Холбооны тойрог
- Хойд Кавказын Холбооны тойрог
- Уралын холбооны тойрог
- Ижил Мөрний Холбооны тойрог
- Сибирийн холбооны тойрог
- Алс Дорнодын Холбооны тойрог





БҮГД НАЙРАМДАХ САХА УЛС

ЯКУТ

Орос бол газар нутгийн хэмжээгээрээ дэлхийн хамгийн том улс юм. Зөвхөн энэ баримт нь “Орос гэж ямар улс байдаг вэ?” гэж асуудаг гадаад хүмүүсийн хувьд тус улсыг сонирхолтой болгодог. Харин Орос бол өөр өөр байдаг шүү найзууд аа. Түүний олон талт байдал нь зөвхөн газарзүйн байршлаас гадна угсаатан үндэстний гайхалтай бүрэлдэхүүнээр тодорхойлогддог. Бид дугаар бүрт гайхалтай газрууд, алдартай зүйлс, хотууд болон бүхэл бүтэн бүс нутгуудын талаар ярьдаг. Өнөөдөр бид уншигчдаа Якут руу аялахыг урьж байна.

ГАЗАР ЗҮЙ

Якут бол үнэхээр гайхалтай газар. Сибирийн зүүн хойд хэсэгт байрлах асар том газар нутаг нь Аргентинаас том талбайтай бөгөөд хойд талаараа Лаптевын болон Зүүн Сибирийн тэнгисийн усаар хязгаарлагддаг.

Якут бол гайхалтай эрс тэс ялгаатай нутаг: төгсөшгүй тундрын дараа арктикийн цөл эхлэж, сэтгэл хөдөлгөм мөсөн голуудтай зэрэгцэн халуун рашаан урсаж, хүчирхэг гол мөрөн толин нууруудтай ээлжлэн байрлаж, эртний хад чулуунууд үзэсгэлэнт хөндийг чимсэн байдаг. Энд, Сибирийн зүрх нутагт байгаль дэлхий жинхэнэ урлагийг хэрхэн бүтээж байгааг харж болно. Энэ нутагт цаст уулын оргилууд ургамал, амьтны гайхалтай олон янз байдал, тэр дундаа ховор, дархан цаазат амьтад, ургамлыг хадгалсан ногоон ой модтой зэрэгцэн оршдог.

Якут бол хүний аж ахуйн үйл ажиллагаа онгон дагшин байгальд бараг хүрээгүй нутаг. Энэ нь газарзүйн байршил, хүн ам багатай байдал, газар нутгийн тэгш бус рельеф, эрс тэс уур амьсгалтай холбоотой юм. Үүний зэрэгцээ энэ бол аж үйлдвэр, боловсрол, шинжлэх ухааны өндөр чадавхитай, хөгжсөн дэд бүтэц болон баялаг соёл бүхий бүс нутаг юм.

ЯКУТСК


Якутск – Бүгд Найрамдах Саха (Якут) Улсын нийслэл – онцгой уур амьсгал, ирээдүйтэй байдлаараа хүмүүсийг татдаг орчин үеийн бизнес, соёлын амьдралын төв хот. Лена голын эрэг дээр байрладаг энэ хот нь эрчимтэй хөгжил болон цаг уурын эрс тэс уур амьсгал дахь Сибирийн байгаль ба хойд зүгийн хотжилтын зохицсон хослолын бэлэг тэмдэг болсон.

Үндэсний уламжлал, ардын урлалаар илэрхийлэгддэг сонирхолтой түүх, соёлын өв бүхий тус хот нь зүгээр газрын зураг дээрх цэг биш, харин хуучин ба шинийг нэгтгэж, амьдрах, ажиллах, хөгжих баялаг бөгөөд сэтгэл татам сайхан орчинг бүрдүүлсэн газар юм. Энд технологийн томоохон төвүүд хөгжиж, бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай нөхцөл бүрдсэн. Соёлын амьдрал нь маш баялаг: Якутск хотод төрөл бүрийн арга хэмжээ, баяр наадам, концерт, театрын үзүүлбэрүүд зохион байгуулагдаж, орчин үеийн цэцэрлэгт хүрээлэн, худалдааны төвүүд, спортын байгууламжууд нь тус хотыг амьдрах ба амрах тав тухтай газар болгодог.

Мөнх цэвдэг бүсэд оршдог хамгийн том хот нь 350 000 гаруй оршин суугчтай бөгөөд байнга өссөөр байна. Хөдөлмөр эрхлэх боломжтой хүн амын 60 гаруй хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт ажилладаг бөгөөд энэ нь тус салбарын хөгжил ба олон төрлийн бараа, үйлчилгээний хүртээмжтэй байдлыг илтгэж, Якутск хотыг амьдрах тав тухтай орчин болгож байна.



Нина Слепцова



getty.livejournal.com


ЭДИЙН ЗАСАГ

Бүс нутгийн эдийн засаг нь уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн салбар дээр суурилдаг. Якутын газрын хэвлий нь олон төрлийн эрдэст түүхий эдээр баялаг байдаг. Алмаз, алт, уран, сурьма, төмрийн хүдэр, нүүрс, тугалга, мөнгөн ус, нүүрс устөрөгч, газрын ховор металлын хайгуулын нөөцийн хэмжээ нь үнэхээр гайхалтай. Оросод олборлосон алмазын 95 хувь нь Якутаас гаралтай байдаг. Ашигт малтмалын баялаг байдал ба аж үйлдвэрийн дэд бүтэц нь Якутыг хөрөнгө оруулагчдын хувьд сонирхолтой бүс нутаг болгодог. Бүгд Найрамдах Саха Улс нь аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийн үзүүлэлтээр улсын тэргүүлэгч бүс нутгуудын нэг юм. 2022 онд Якутын эдийн засагт 616,2 тэрбум рублийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Тээврийн систем нь авто зам, төмөр зам, усан болон агаарын тээврээс бүрддэг. Ачааны урсгалын томоохон хэсгийг том гол мөрөн, Хойд тэнгисийн замаар усан тээврээр гүйцэтгэдэг. Өвлийн улиралд гол мөрний зам зогсоход агаарын тээврийн үүрэг ихээхэн нэмэгддэг. Бүгд Найрамдах Улсад 23 нисэх онгоцны буудал үйл ажиллагаа явуулдаг.

Орчин үеийн технологийн шийдэл болон инновацийг нэвтрүүлснээр бүс нутгийн хөдөө аж ахуйн хөгжлийг шинэ шатанд гаргаж байна. Мөнх цэвдэг бүсэд газар тариалан, мах сүүний аж ахуй, загас агнуурын аж ахуйн үйл ажиллагааг амжилттай явуулах туршлагыг улсын хэмжээнд идэвхтэй судалж, дэмжиж байна. Хүлэмжийн аж ахуйн хэмжээ өсч байна.

Якутын эдийн засагт дэд бүтэц ба тээврийн холбоог өргөжүүлэх ажил чухал үүрэг гүйцэтгэдэг. Лена голын төмөр замын гүүр зэрэг дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх нь бүс нутгийн боломжийг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын сонирхлыг татахад тусалдаг.



"Мир" уурхай үерт автсанаас хойш 5 жилийн дараа Мирний хот, Бүгд Найрамдах Саха (Якут) Улс



Якут улс боловсрол, шинжлэх ухааны хөгжилд идэвхтэй хөрөнгө оруулалт хийж байгаа бөгөөд энэ нь мэргэжлийн өндөр түвшний мэргэжилтнүүдийг бэлтгэх ба бүх салбарын инновацийн өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлдэг. Мэдээллийн технологийн салбар эрчимтэй хөгжиж байна – програм хангамж, сервис, апп, тоглоом хөгжүүлдэг олон амжилттай компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

Энэ бүхнээс харахад Якутын эдийн засаг хөгжиж байгаа нь харагдаж байна. Тус бүс нутаг нь бизнес, хөрөнгө оруулалт, хувь хүний хөгжлийн таатай орчныг бүрдүүлснээр байгалийн нөөц бололцоогоо орчин үеийн инновацитай амжилттай хослуулж байна.

ҮНДЭСНИЙ ОНЦЛОГ ЧАНАР

Бүгд Найрамдах Саха (Якут) Улс бол якут үндэстэн давамгайлсан олон үндэстний бүс нутаг юм. Энэ нь соёлын ба өдөр тутмын амьдрал, амралт чөлөөт цагт нөлөө үзүүлдэг. Якутын тухай ярихдаа бид тус нутгийн хоол, баяр ёслол, кино урлагийг үл тоомсорлож чадаагүй юм.

Нийт оросын баяр ёслолоос гадна Якутад дараах үндэстний баяруудыг тэмдэглэдэг: Ысыах, Бүгд Найрамдах Улсын өдөр, Олонхо, Арктикийн өдөр, Эх хэл, бичгийн өдөр. Эдгээрийн дундаас якутын зуны улирлын уламжлалт баяр болох Ысыах баяр маш их сонирхол татдаг.

Ысыах баярыг Якутын гол үндэстний баяр ба Бүгд Найрамдах Улсын хамгийн том соёлын үйл явдал гэж нэрлэж болно. Зуны туйлын өдрүүд буюу 6-р сарын сүүлийн өдрүүдэд бүх суурин газруудад наадам, баяр цэнгээн явагддаг. Энэхүү тод баяр нь Төв Ази, Өмнөд Сибирь, Кавказын Түрэг үндэстний ард түмнүүдийн эрт дээр үеийн уламжлалыг нэгтгэдэг. Ысыах баярын үед өдөр ба шөнийн цагт баярын гал унтардаггүй бөгөөд Айыы бурханыг хүндэтгэн цусгүй тахил өргөдөг, мөн мэргэ хийж, тоглоом тоглож, бүжиг бүжиглэдэг.



Нина Слепцова





Бүгд Найрамдах Улсын өдөр Айсен Николаев
Платон Ойункскийгийн хөшөөнд цэцэг өргөв



ysia.ru



ysia.ru



Matyas Havel

Ямар ч баяр ёслол хоолны ширээ засахгүйгээр өнгөрдөггүй. Якут үндэсний хоол нь олон тансаг хоол санал болгодог. Якутын уламжлалт хоолонд мах, загас, сүүн бүтээгдэхүүн, олон төрлөөр бэлдсэн жимсгэнэ ба ургамлууд багтдаг. Бүс нутгийн байгалийн ширүүн нөхцөл нь жимс ба ихэнх хүнсний ногоо тарих боломжийг олгодоггүй тул уламжлалт хоолонд жимс ногоо байдаггүй. Үүнээс гадна, хоол хийх явцад анхдагч бүтээгдэхүүний бүх хэсгүүдийг ашигладаг онцлог бий. Тухайлбал, амьтны таван цул, яс, мөгөөрс, цусыг хоолонд хэрэглэдэг.

Хамгийн алдартай үндэсний хоол:

- **Хаан** – үхрийн эсвэл унаганы цусаар хийсэн амтлаг цусан хиам
- **Ойгос** – халуун (жигнэсэн), чанаж болгоод хөлдөөсөн эсвэл хөлдөөсөн түүхий мах хэлбэрээр ширээнд тавьдаг адууны эсвэл унаганы мах (ихэвчлэн цээж мах)
- **Хөлдөөсөн түүхий мах** – давс, хар нунтаг чинжүүтэй ширээнд тавьдаг нимгэн зүссэн хөлдөөсөн загас, унаганы мах эсвэл элэг
- **Ис миинэ** – шинэхэн ногоон сонгинотой бэлддэг төмс, жижиг гоймонтой таван цулын шөл
- **Кёрчэх** – аньс эсвэл цангис жимсгэнэтэй тослог цөцгийгөөр хийдэг үндэсний амттан

ХААШАА ЯВАХ, ЮУ ҮЗЭХ, ЮУ ХАРААХ ГАЙХШРАХ ВЭ

Якут бол маш өргөн уудам, олон талт бөгөөд заримдаа бүрэн ойлгох боломжгүй байдаг. Тэр энд ирсэн хүмүүсийн зүрх сэтгэлд үүрд үлддэг. Бүс нутаг болон нийслэл хотын олон тооны онцгой үзмэрүүд ба гайхамшигтай газрууд танд заавал таалагдах болно. Бид уншигчдад зориулж Бүгд Найрамдах Улс, түүний өв уламжлал, байгаль орчин, түүх, мэдээжийн хэрэг оршин суудаг хүмүүсийн тухай ойлголттой болохын тулд заавал очих ёстой газруудын жагсаалтыг бэлдлээ.

«ЯКУТЫН ЭРДЭНЭСИЙН САН»

Якут нутгийн жинхэнэ байгалийн ба эрдэст баялгийн талаар өргөн ойлголт өгөх онцгой үзэсгэлэн. Үзэсгэлэнгийн танхимуудад үнэт металлын олборлолт ба боловсруулалтын түүх, үнэт эдлэлийн урлаг, үнэт болон хагас үнэт чулууны гайхалтай төрөл зүйлийг танилцуулсан байдаг.

📍 Якутск, Кировын гудамж, 12

АРСЛАН ЗААНЫ МУЗЕЙ

Дэлхийн арслан зааны музей 1991 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд өнөөдөр тус музей нь Зүүн хойд Холбооны их сургуулийн бүтцийн нэгж юм. Музей-лабораторийн үзэсгэлэнгийн танхим ба сан хөмрөг нь бүхэлдээ арслан зааны судлалын асуудалд зориулагдсан бөгөөд энэ нь дэлхийн хэмжээнд чухал ач холбогдолтой байдаг, учир нь нийт мэдэгдэж байгаа арслан зааны оршуулгын 75% нь Якутын нутаг дэвсгэрээс олдсон байдаг. Эндээс эртний амьтдын хадгалагдан үлдсэн занданшуулсан шарилыг харж болно. Олон үзмэрүүд дэлхийд өөр хаана ч байдаггүй.

📍 Якутск, Кулаковскийн гудамж, 48, КФЕН

ЛЕНА МӨРНИЙ ЧУЛУУН БАГАНУУД

Лена мөрний чулуун баганууд байгалийн цэцэрлэгт хүрээлэн нь Лена мөрний эрэг дагуу 40 гаруй км үргэлжилсэн төрөл бүрийн хэлбэр бүхий сүрлэг хадан цохионууд юм. Эдгээр байгалийн тогтоцууд 400 мянган жилийн настай. Энэ бол байгалийн жинхэнэ гайхамшиг бөгөөд энд цаг хугацаа үл мэдэгдэхээр өнгөрч буйг мэдрэх боломжтой.

📍 Якутск, Крупская, 13

📍 Покровск, Орджоникидзе, 56





МӨНХ ЦЭВДЭГИЙН ХААНТ УЛС

Энэхүү аялал жуулчлалын цогцолбор нь музей ба үзвэр үйлчилгээ бүхий уулын доторх хайлдаггүй асар том мөс юм. Цогцолборын дулааны хэм хэзээ ч -4°C -аас хэтэрдэггүй. Аяллын үед даарахгүйн тулд зочид тусгай дулаан хувцас өмсдөг.

📍 Якутск, Чочур-Муран уул, 7 км, 1



«ЧОЧУР-МУРАН» БАЙГАЛЬ ОРЧИН, УГСААТНЫ ЗҮЙН ЦОГЦОЛБОР

Уулын бэлд 2005 онд нээгдсэн уг цогцолбор нь өвөрмөц засал чимэглэл бүхий худалдаачны байр, амбаар, каярын (нохойн чарганы жолооч) болон анчны байшин байрласан өргөн уудам нутаг дэвсгэр юм. Зочид Уралын цаад нутгийн анхны судлаачдын аж ахуйтай танилцаж, тэдний түүхийг мэдрэх боломжтой.

📍 Якутск, Вилюйский зам, 7 км, 5-р байр



БУЛУУС МӨС

Энэ бол олон юм үзсэн аялагчдын сэтгэлийг хөдөлгөж чаддаг байгалийн өвөрмөц газар юм. Агаарын хэм $+35^{\circ}\text{C}$ -д хүрдэг зуны улиралд ч хайлдаггүй тус үзэсгэлэнт мөс нь Бүгд Найрамдах Улсын нийслэлээс 100 километрийн зайд байрладаг. Мөсний дээрх дулааны хэм жилийн турш $+4^{\circ}\text{C}$ орчим байдаг. Энэхүү гайхалтай цогцолборын нутаг дэвсгэрт цэвэр устай олон булаг шанд, үзэсгэлэнтэй газрууд байдаг.



«Якутын эрдэнэсийн сан», виртуал аялал



Лена мөрний чулуун баганууд, интерактив газрын зураг



«Чочур-Муран» байгаль орчин, угсаатны зүйн цогцолбор, виртуал аялал

ЯКУТЫН «ГОЛЛИВУД»

Сүүлийн жилүүдэд Якутын кино урлагийг «кино гайхамшиг» гэж нэрлэх болсон. Якут кино нь Оросын киноны тайзанд барууны кино үйлдвэрлэл болон Оросын шилдэг кинонуудаас түрүүлж байгаа нь гайхах зүйл биш юм. 2022 онд Якутын 28 кинонд 225 000 тасалбар зарагдсан байна. Энд инээдмийн болон аймшгийн киноноос эхлээд түүхэн драм хүртэл бүх төрлийн киноны зураг авалт явагддаг. Зохиолчын кинонууд кино наадамд тогтмол оролцож, шагналууд хүртдэг.

Якут кино бол ширүүн, энгийн орчин ба интерьерд чин сэтгэлийн тухай, өдөр тутмын амьдралын драмын тухай, нийгмийн өвдөлтийн тухай кино юм. Якут кино нь үргэлж хүмүүсийн тухай кино байдаг.

ЮУ ҮЗЭХ ВЭ



БАЙЛДАГЧ ЧЭЭРИН (2021)

1943 оны хүнд байлдаан тулалдаан ба Германы мэргэжлийн буудагчтай мэргэн буучдын тулаанд орсон Якут анчны тухай байлдааны триллер кино. Тимофей Сметаниний «Егор Чээрин» хэмээх дайны зохиолоос сэдэвлэсэн, байлдааны урд шугамын мэргэн буудагч, тагнуулчдын ажлын тухай сэтгэл хөдөлгөм кино.



НАД ДЭЭР НАР ЖАРГАДАГГҮЙ (2019)

Аав хүүгийн харилцааны мөнхийн сэдэвтэй хөнгөн, тайван кино. Лаптевын тэнгисийн ойролцоох алслагдсан арал дээр хоёр өөр үеийн хүмүүс уулзав. Тэдний нэг нь орчин үеийн нийгмийн энгийн төлөөлөгч болох Алтан хэмээх нэртэй залуу. Нөгөө хүн нь эртний уламжлалыг баримтлагч, Якут соёлын амьд биелэл болсон Байбал хэмээх нэртэй өвгөн. Тэднийг Байбалын охиныг олох гэсэн нэг зорилго нэгтгэдэг.



МАНУУХАЙ (2020)

Ганцаардлын хүнд ачааны тухай өгүүлсэн сэтгэл хөдөлгөм драм. Киноны баатар бол эмч, бадарчин эмэгтэй. Түүнийг насанд хүрэгчид үзэн ядаж, хүүхдүүд айдаг ч гэсэн зовлон ирэхэд тэр цорын ганц аврал болдог. Энэ ур чадвар түүний хувьд хараал боловч өнгөрсөнд нуусан бүрхэг нууц нь түүнийг дахин дахин хүмүүст туслахад хүргэдэг.

SAKHA WOOD

Мина Слепцова



М. К. АММОСОВЫН НЭРЭМЖИТ ЗҮҮН ХОЙД ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬ

Үүсгэн байгуулагдсан он – 1956

548

сургалтын
хөтөлбөр

258

бакалавр ба
специалитетын
хөтөлбөр

119

магистрын
хөтөлбөр

101

аспирантурын
хөтөлбөр

59

ординатурын
хөтөлбөр

11

мэргэжлийн дунд
боловсролын
хөтөлбөр

Зүүн хойд Холбооны Их сургууль бол чанартай боловсрол ба шинэлэг сэтгэлгээний биелэл юм. 120 гаруй жилийн өмнө үүсгэн байгуулагдсан тус их сургууль нь өнөөдөр Орос ба дэлхийн шинжлэх ухааны бахархал болсон байна. Манай хөтөлбөрүүд техникийн, байгалийн ухааны, хүмүүнлэгийн болон ерөнхий боловсролын чиглэлийн өргөн хүрээний мэдлэгийг санал болгодог.

18

хүрээлэн ба
тэнхим

18 000+

оюутан

1 200+

дэлхийн 53 улсын
1 200+ гадаад
оюутан

Түнш байгууллагууд, бүс нутгийн болон улсын томоохон аж ахуйн нэгжүүд, ажил олгогчидтой хамтран ажилласнаар бид төгсөгчдийн өндөр түвшний бэлтгэлийг хангаж ажилладаг. Залуу мэргэжилтнүүд хөдөлмөрийн зах зээлд хялбар дасан зохицож, их сургуульд суралцаж байхдаа ажлаа олж чаддаг.



www.s-vfu.ru

t.me/svfunews

vk.com/svfuniver

youtube.com/c/videosvfu



Нэг жилийн сургалтын төлбөр

**Бакалавр/специалитет –
160 000–180 000 RUB**

Магистр – 173 000–184 000 RUB

Аспирантур – 198 000 RUB

Ординатур – 198 000 RUB



1501+
дэлхийд

42
Орост



401-600
Нэгдсэн рейтинг



27

приоритет2030*
лидерами становятся

📍 Орос, Бүгд Найрамдах Саха (Якут) улс, Якутск

ЭЛСЭЛТ**ОХУ-ын квотын дагуу үнэ төлбөргүй суралцах эрхээр**

- education-in-russia.com системд бүртгүүлж, шаардлагатай бичиг баримтуудыг оруулна уу
- Өөрийн улс дахь Россотрудничество-ийн (РЦНК) Төлөөлөгчийн газарт сонгон шалгаруулалтад оролцоно уу
- Анкет бөглөхдөө хамгийн эхний мөрөнд «ЗХХИС»-ийг заана уу
- ЗХХИС-д суралцах чиглэл авна уу

төлбөртэй сургалтын гэрээгээр

- abit.s-vfu.ru порталд бүртгүүлж, 6-р сарын 20-с хойш шаардлагатай бичиг баримтуудыг оруулна уу
- 7-р сарын 16-аас 8-р сарын 28 хүртэх хугацаанд цахимаар элсэлтийн шалгалтаа өгнө уу
- Элсэлтийг хүлээн зөвшөөрөх мэдэгдэл ба гэрээнд гарын үсэг зурна уу

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ

- **Бакалавр/специалитетын хөтөлбөрт:** цахим шалгалт (зарим мэргэжлээр элсэхийн тулд бүтээлч уралдаанд оролцох ёстой)
- **Магистрын хөтөлбөрт:** цахим аман ярилцлага

**ЭЛСЭЛТИЙН КОМИСС**

- ✉ priem@s-vfu.ru
- ☎ +7 4112 25-11-22
- ☎ +7 4112 49-69-62
- ☎ +7 4112 36-14-53

ШААРДЛАГАТАЙ БИЧИГ БАРИМТУУД

- Биеийн байцаалт + нотариатаар баталгаажуулсан орчуулга
- Өмнөх боловсролын гэрчилгээ + нотариатаар баталгаажуулсан орчуулга
- Эрүүл мэндийн байдлын дүгнэлт, ХДХВ-ийн халдваргүй гэсэн гэрчилгээ + нотариатаар баталгаажуулсан орчуулга

**ЗХХИС-ИЙН ОЮУТНЫ БАЙРАНД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АМЬДРАХ КУПОН!**

Суурь боловсролын болон бэлтгэл ангийн хөтөлбөрт элсэх тохиолдолд

**БЭЛТГЭЛ АНГИ****Их сургуулийн өмнөх бэлтгэлийн чиглэлүүд:**

- техникийн
- хүмүүнлэгийн
- ерөнхий боловсролын
- анагаах ухааны
- инженерийн

Гадаад оюутнууд орос хэл сурч, улс ба бүс нутгийн соёл, уламжлалтай танилцдаг. Түүнээс гадна, бэлтгэл ангид үндсэн мэргэжлийн сургалт явагддаг бөгөөд төгссөний дараа оюутнууд ЗХХИС-д элсэх элсэлтийн шалгалт өгөх боломжтой.

Үнэ 118 000-172 000 RUB

ОЛИМПИАД

Бакалавр/специалитетын хөтөлбөрт элсэх үед нэмэлт оноо авахын тулд гадаадын иргэдэд зориулсан сургуулийн сурагчдын Зүүн Хойд олимпиадын ялагч ба шагналт байрын эзэд, онц төгссөн боловсролын үнэмлэх, Оросын ба олон улсын уралдаан, олимпиадад оролцсон гэрчилгээг харгалзан үзнэ.

ОХУ-ийн Квотын хүрээнд улсын төсвийн санхүүжилттэй байгууллагуудын магистрын хөтөлбөрт хамрагдах боломжийг олгодог ЗХХИС-ын олимпиадууд:

- Олон улсын оролцоотой математикийн бүх Оросын оюутны олимпиад (БООО)
- Сурган хүмүүжүүлэх, Эдийн засаг ба Хууль зүйн чиглэлээр магистрын хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй элсэгчдэд зориулсан холбооны их дээд сургуулиудын олимпиад

ТЭТГЭЛЭГ

Их сургуулийн нийгмийн болон шинжлэх ухааны амьдралд өөрийгөө харуулсан, идэвхтэй оюутнуудад олгодог «NEFU Scholarship» нэг удаагийн тэтгэлэг.



Шинжлэх ухаан




Монгол оюутнууд

ЗХХИС-Д ЭЛСЭХ 10 ШАЛТГААН

- 1 Боловсролын чанар ба хүртээмж:** ЗХХИС нь шинжлэх ухааны ба сурган хүмүүжүүлэх хүчирхэг ажилтнуудын дэмжлэг бүхий олон төрлийн дээд боловсролын хөтөлбөрүүдийг санал болгодог.
- 2 Сонирхолтой мэргэжлүүд:** ЗХХИС нь инженерчлэл, анагаах ухаан, урлаг, хүмүүнлэгийн шинжлэх ухаан зэрэг олон салбарын хөтөлбөрүүдийг санал болгодог.
- 3 Дасан зохицох, нийгэмшүүлэх үр дүнтэй тогтолцоо нь** дэлхийн өнцөг булан бүрээс хүрэлцэн ирсэн оюутнуудын үндэстэн хоорондын харилцаа тогтооход эерэгээр нөлөөлдөг.
- 4 Өндөр хэмжээний тэтгэлэг** (төсвийн зардлаар сурдаг оюутнуудад).
- 5 Боловсролын бүх түвшний оюутнуудын суралцах үедээ ажилд орох боломж.**
- 6 Мэргэжлийн боломжууд:** ЗХХИС нь тэргүүлэх компани болон байгууллагуудтай хамтран ажиллаж, оюутнуудад мэргэжлийн өргөн боломжуудыг олгодог.
- 7 Оюутны амьдрал:** оюутны төрөл бүрийн байгууллага, арга хэмжээ, клубууд нь оюутны эрчимтэй бөгөөд сонирхолтой амьдралыг бий болгодог.
- 8 Хөгжсөн дэд бүтэц бүхий тохилог оюутны хотхон** нь дэлхийн өнцөг булан бүрээс хүрэлцэн ирсэн оюутнуудын найрсаг нийгэмлэг юм. Оюутнууд орчин үеийн номын сан, биеийн тамирын байгууламжийг ашиглах, соёлын арга хэмжээнд хамрагдах боломжтой.
- 9 Олон улсын харилцаа:** тус их сургууль нь дэлхий даяарх их дээд сургуулиуд ба байгууллагуудтай идэвхтэй харилцаа холбоотой байж, олон улсын боломжуудын үүдийг нээдэг.
- 10 Арктикийн судалгаа:** тус их сургууль нь Хойд туйлын байгаль, цаг уурын судалгааны тэргүүлэгч байгууллага бөгөөд энэ сэдвийг судлах онцгой боломжоор хангадаг.

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХҮРЭЭЛЭН

Сургалтын хэл – орос хэл 

Биеийн тамир, спортын хүрээлэнд жил бүр Монголоос олон элсэгчид ирдэг. Ийм алдартай байх нь цаанаа учиртай бөгөөд үүний талаар тусад нь ярьж өгөх хэрэгтэй.

Баттогтох Бат-Өлзий 2021 онд ЗХХИС-ийн “Монгол, Якутын чөлөөт бөхийн хөгжлийн харьцуулсан судалгаа” сэдвээр дипломын ажил бичиж, магистрын зэрэг хамгаалсан. Дипломоо хамгаалсаны дараа энэ залуу нутагтаа буцан ирж, одоо мэргэжлээрээ ажиллаж байна.

Баттогтох Бат-Өлзий Якут, Монголын дээд зэрэглэлийн тамирчдад зориулсан чөлөөт бөхийн хамтарсан бэлтгэлийг хоёр удаа зохион байгуулж, хүрээлэн болон Бүгд Найрамдах Саха (Якут) улсын биеийн тамирын бэлтгэлийн төвтэй үргэлжлүүлэн хамтран ажиллассаар байна.

Баттогтох Бат-Өлзийгийн зөвлөснөөр ЗХХИС-д элссэн хоёр монгол эмэгтэй тамирчин өнөөдөр Спортын онол арга зүй, спортын кинезиологи, эрүүлжүүлэх ба дасан зохицох биеийн тамирын тэнхимд суралцаж байна. Тэд чөлөөт бөхөөр хичээллэдэг бөгөөд ирээдүйд спортын өндөр амжилтад хүрэх их итгэл найдвар төрүүлж байна.

Монголын тамирчид бэлтгэл сургуулилын өндөр түвшин харуулдаг. Тэд мас-реслингийн төрөлд сайн амжилт үзүүлдэг, тэдний суурь бэлтгэл нь сайн байдаг. ЗХХИС-д зохион байгуулдаг биеийн тамирын бааз бэлтгэлийн үр дүнгээр үүнийг дүгнэж болно.

Тус хүрээлэн нь орчин үеийн биеийн тамирын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд энэ нь оюутнуудын биеийн тамирын бэлтгэлийг цаашид хөгжүүлэх ба Бүгд Найрамдах Улсад спортыг хөгжүүлэх илүү их боломжийг олгодог. Тус хүрээлэн нь өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэдэг тэргүүлэх байгууллага болсон юм. Жил бүр оюутнууд Бүгд Найрамдах Улсад төдийгүй ОХУ-ын Алс Дорнодын бүс нутагт, Оросын ба дэлхийн оюутны аварга шалгаруулах тэмцээнд спортын олон төрлөөр гайхалтай үр дүн үзүүлдэг.



▲ Чөлөөт бөхийн тэмцээн (якут тамирчин А. Тюрин)

▶ «Ректорын цом»
сагсан бөмбөгийн
тэмцээн





Спортын гүүр Монгол – Якут

Бодит байдлаас харахад олон улсын боловсролын туршлага нь мэргэжлийн замналын өрсөлдөөний давуу тал болж байна. Шинэ орчинд нэвтрэх, өөр хэл сурах, олон төрлийн ур чадвар эзэмших, орчин үеийн мэдлэгтэй болох, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицох чадвар зэрэг нь хүчирхэг мэргэжилтэн ба чадварлаг боловсон хүчин бэлтгэдэг. Манай сэтгүүлийн редакц уншигчдадаа Оросын их дээд сургуулийг амжилттай төгссөн шинэ баатруудыг тогтмол танилцуулдаг. Өнөөдрийн манай зочноор Зүүн Хойд Холбооны их сургуулийн Биеийн тамир, спортын хүрээлэнгийн төгсөгч, Монголын Мас-реслингийн холбооны үүсгэн байгуулагч Батбаатар Эрдэнэваанчиг оролцож байна.

Якутад суралцсан, тэр дундаа Зүүн хойд Холбооны их сургуульд суралцсан туршлага бол миний хувьд эерэг бөгөөд амьдралын ба мэргэжлийн чухал туршлага юм. Якутад суралцахаар ирэх боломжийн талаар бодож байгаа хүмүүст зориулж би хэд хэдэн чухал зүйлийг хэлмээр байна.

Нэгдүгээрт, цаг уурын нөхцөл ижил төстэй байдаг. Монгол бол эх газрын эрс тэс уур амьсгалтай орон. Манайд өвөлдөө маш хүйтэн байдаг. Энэ нь надад дасан зохицоход ямар нэгэн саад бэрхшээл тулгараагүйн шалтгаан болсон, би хурдан дассан.

Хоёрдугаарт, гайхалтай дэд бүтэц. Тохилог оюутны хотхон, шинэ оюутны байр, хичээл ба бэлтгэлд шаардлагатай бүх зүйлсийн хүртээмжтэй байдал нь энд тав тухтай амьдрах боломжийг олгодог.

Гуравдугаарт, өөр улс руу нүүх зэрэг эрс өөрчлөлт нь харилцааны хүрээллийг тэлж, шинэ найз нөхөд, шинэ танил хүмүүстэй болдог. Якутууд бол зочломтгой, найрсаг хүмүүс тул надад шинэ хүмүүстэй харилцах нь хялбар бөгөөд тааламжтай байсан. Ангийнхаа зарим хүүхдүүдтэй бид одоо ч гэсэн харилцдаг. Түүнчлэн куратор болон багш нар оюутнуудад үнэлж баршгүй дэмжлэг үзүүлдэг. Би ЗХХИС-ийн Биеийн тамир, спортын хүрээлэнгийн гайхалтай багш нарт, ялангуяа миний куратор Иосиф Иосифович Портнягинд талархал илэрхийлэхийг хүсч байна.

Эцэст нь дөрөвдүгээрт, боловсролын өндөр чанар, хичээл, бэлтгэл болон бусад хичээлийн бус үйл ажиллагааг хослуулах боломжийг олгодог сайн зохион байгуулалттай боловсролын үйл явц. Спортоор хичээллэх дуртай миний хувьд энэ нь маш чухал байсан. Энэ талаараа ЗХХИС маш сайн, би магистр болон аспирантурыг төгсөж чадсан.

ЗХХИС-ийн магистрын хөтөлбөрт элсэхээсээ өмнө би Якутын өөр нэг их сургуульд суралцаж байсан гэдгээ хэлэх ёстой. Би Чурапчагийн биеийн тамир спортын дээд сургуульд бакалаврын зэргээр суралцаж төгссөн. Тэнд сурч байхдаа би ЗХХИС болон тус их сургуулийн магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах боломжтойг мэдэж авсан.

Чурапчагийн биеийн тамир спортын дээд сургуульд би чөлөөт бөхөөр хичээллэдэг байсан. Дараа нь ЗХХИС-д элсээд би мас-реслинг, самбо, жүдо болон бусад төрлийн спортоор хичээллэж эхэлсэн.

Би Мас-реслингийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд гуравдугаар байр эзлэсэн. Энэ нь надад Монголд Мас-реслингийн холбоо байгуулах түлхэц өгсөн. Тэр үеэс хойш би эх орондоо Якутын үндэсний спортын төрлүүдийг сурталчилж, жил бүр Якутад ирж тэмцээнд оролцдог.

Батбаатар Эрдэнэваанчиг, Монгол Улс. Зүүн Хойд Холбооны их сургуулийн Биеийн тамир, спортын хүрээлэнгийн төгсөгч, Монгол улсын Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн захирал





АРКТИКИЙН УЛСЫН СОЁЛ, УРЛАГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ

Үүсгэн байгуулагдсан он – 2000

43

боловсролын
хөтөлбөр

2

аспирантурын
чиглэл

20

2024 онд гадаадын
иргэдэд зориулсан
үнэ төлбөргүй
суралцах 20 эрх

**АУСУДС-д Бүгд Найрамдах Саха (Якут) улс,
Оросын өөр бүс нутаг, Киргиз, Монгол
улсаас ирсэн 796 оюутан суралцдаг.**

Арктикийн улсын соёл, урлагийн дээд сургууль (АУСУДС) бол Оросын хамгийн том бүс нутаг болох Зүүн хойд Арктикийн бүсэд соёл, урлагийн чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг Оросын цорын ганц суурь, бүс нутгийн их сургууль юм.

АУСУДС нь Арктикийн хүн ам багатай ард түмнүүдийн уран бүтээлийн чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэхдээ алдартай, тэргүүлэх байгууллагуудын нэг юм.



- agiki.ru
- vk.com/agiki_official
- t.me/agiki_14

Нэг жилийн сургалтын төлбөр

65 000–158 000 RUB



приоритет2030⁺

лидерами становятся

2022 онд АУСУДС нь улсын дэмжлэг үзүүлэх «Тэргүүлэх чиглэл 2030. Алс Дорнод» хөтөлбөр орсон бөгөөд үүний ачаар тус сургууль нь эрчимтэй хөгжиж, шинэ сургалтын хөтөлбөрүүд нэвтрүүлж, материалын хангамжаа сайжруулж байна.

📍 Орос, Бүгд Найрамдах Саха (Якут) улс, Якутск

ЭЛСЭЛТ

Гадаадын элсэгчид АУСУДС-д хоёр аргаар элсэх боломжтой:

1 Нэгдүгээрт, үнэ төлбөргүй!

Үүний тулд намар (хугацаа нь өөрчлөгдөж болно) Россотрудничество-ийн education-in-russia.com албан ёсны порталаар элсэлтийн хүсэлт илгээж, үнэ төлбөргүй суралцахаар элсэх боломжтой.

Россотрудничество-ийн шугамаар АУСУДС-д дараах чиглэлээр үнэ төлбөргүй өдрийн ангид суралцах боломжтой:

- «Хэрэглээний мэдээлэл зүй»
- «Ардын уран сайхны соёл» («Кино, гэрэл зураг, видео студийн удирдлага», «Угсаатны соёлын төвийн удирдлага», «Сонирхогчдын бүжгийн хамтлагын удирдлага» мэргэжлүүд)
- «Нийгэм, соёлын ажил»
- «Номын сан, мэдээллийн ажил»
- «Хөгжим, зэмсэгийн урлаг»
- «Хэрэглээний чимэглэлийн урлаг, ардын урлал»
- «Жүжиглэх урлаг»
- «Уран зураг»
- «График»

Үнэ төлбөргүй суралцахаар элссэн оюутнуудыг дараах зүйлсээр хангана:

- Тэтгэлэг
- Орчин үеийн тохилог оюутны байр

2 Хоёрдугаарт, шууд АУСУДС-д өргөдөл гаргаж, төлбөртэй суралцахаар элсэх боломжтой.

Россотрудничество-ийн порталыг анхааралтай хянаж, Монгол дахь Оросын соёлын төвийн арга хэмжээнд оролцож, АУСУДС-ийн сайт руу орж байгаарай. Элсэлтийн шалгалт эсвэл нэмэлт уран бүтээлийн шалгалтын шаардлагыг хараад санаа зовох хэрэггүй. Элсэлтийн комиссийн ажилтан залгахад хариулахын тулд элсэлтийн үед холбоотой байхыг хичээгээрэй.

**Анхаар!**

АУСУДС нь зарим уран бүтээлийн чиглэлээр элсэлтийн шалгалтыг зайнаас авдаг. Таны хүсэлт Россотрудничество-ийн портал дахь АУСУДС-ийн хувийн танхимд ирсэний дараа шалгалт явагддаг, үүний тулд элсэлтийн комиссийн ажилтнууд таны хүсэлтэд заасан утасны дугаараар холбогдох болно.

**ЭЛСЭЛТИЙН КОМИСС**

✉ priem2024@agiki.ru
☎ +7 4112 42-11-67

СУРГАЛТ

АУСУДС-д хөгжим, урлаг, нийгэм соёл, театрын чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг.

2023 оноос эхлэн АУСУДС нь дээд боловсролын хоёр шинэ боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлүүлж байна:

- «Ардын уран сайхны соёл» чиглэл, («Кино, гэрэл зураг, видео студийн удирдлага» мэргэжил
- «Номын сан, мэдээллийн ажил» магистрын чиглэл, «Дижитал орчин дахь номын сангийн ажлын танин мэдэхүй судлалын онол, арга зүй» мэргэжил

Мөн нээлттэй, эрэлттэй боловсролын хөтөлбөрүүдэд элсэлт авч байна:

- «Орон зайн дизайн»
- «Дижитал график дизайн»
- «Хувцасны загвар, нэхмэл эдлэл»
- «Үнэт эдлэлийн дизайн»



Тус дээд сургуульд Хойд зүгийн ард түмнүүдийн соёлын кодын гүн түүхийг судалдаг хоёр лаборатори ажилладаг. Үнэт эдлэлийн дизайны шинжлэх ухааны дэмжлэгийн хангах зорилгоор Үнэт эдлэлийн дизайны лаборатори байгуулагдаж байгаа.



«ДИЗАЙН»**Өдрийн анги**

Элсэгчдийн улс орнуудын боловсролын яамтай хамтран Россотрудничество нь элсэлтийн шалгалтыг зохион байгуулдаг. Элсэлтийн өмнөх жилийн намраас эхлэн Россотрудничество, Монгол дахь Оросын соёлын төв, Монгол Улсын Боловсролын яамны зарлалыг анхаарч эхлэх хэрэгтэй.



Монголоос ирсэн оюутнууд болох Нямжав Оргилбаяр (3 курс), Уянга Батхүү (2 курс) нар АУСУДС-ийн Ардын уран сайхны соёлын тэнхимд «Сонирхогчдын бүжгийн хамтлагын удирдлага. Багш» мэргэжлээр суралцдаг.

**ТЭТГЭЛЭГ**

Россотрудничество-ийн шугамаар төсвийн зардлаар суралцахаар элссэн АУСУДС-ийн гадаад оюутнууд сургалтын дүнгээс үл хамааран нийт сургалтын хугацааны турш ОХУ-ын төсвөөс улсын тэтгэлэг авдаг. Улсын тэтгэлэгийн хэмжээ нь 7 000–8 500 RUB байдаг.

**ДАСАН ЗОХИЦОХ**

Гадаад оюутнуудад дасан зохицоход нь туслах зорилгоор гадаад оюутнуудыг Якутын түүх, соёлтой танилцуулах соёлын арга хэмжээ, сэдэвчилсэн концерт, харилцан яриа, кино үзүүлбэр, биеийн тамир, зугаа цэнгэлийн арга хэмжээ, форум, буухиа уралдаан, квест тоглоом, уран бүтээлийн тэмцээн, наадам зохион байгуулдаг. Тус дээд сургуулийн оюутнууд оюутны байгууллагуудын үйл ажиллагаа, сайн дурын хөдөлгөөнд идэвхтэй оролцдог.



ЧУРАПЧАГИЙН УЛСЫН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ДЭЭД СУРГУУЛЬ

Үүсгэн байгуулагдсан он – 1999

9

бэлтгэлийн чиглэл

9

боловсролын
хөтөлбөр

700+

оюутан

Оюутнуудын 95 гаруй хувь нь төгссөний дараа ажилд ордог. Тус дээд сургуульд спортын олимпийн болон олимпийн бус төрлүүдийг хөгжүүлдэг.

Чурапчагийн улсын биеийн тамир, спортын дээд сургууль нь хөдөө орон нутгийн эрс тэс мөнх цэвдэг бүсэд байдаг байрладаг Оросын цорын ганц дээд сургууль юм. Тус дээд сургууль нь биеийн тамир, спортын чиглэлээр багшлах боловсон хүчнийг бэлтгэх ба давтан сургах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. “Биеийн тамир”-ын чиглэлийн бакалавр, магистр, дасгалжуулагч, багш нарыг сургаж бэлтгэдэг.

Тус сургуульд Якут, Бүгд Найрамдах Тува, Беларусь, Узбекистан, Монголын оюутнууд суралцдаг.



Сургалтын жилийн төлбөр

Бакалавр 140 000 RUB

Магистр 160 000 RUB



new.chgifikis.ru

vk.com/public211922123

📍 Орос, Бүгд Найрамдах Саха Улс (Якут), Чурапча суурин газар

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ**Бакалавр**

- Орос хэл
- Биологи
- Биеийн тамирын ерөнхий бэлтгэл
- Биеийн тамирын онолын тест

Магистр

- Ярилцлага

ХАРГАЛЗАЖ ҮЗЭХ ХУВИЙН АМЖИЛТ

- Олимпийн аварга, олимпийн медальтай байх
- Дэлхийн аварга, Европын аварга байх
- Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний ялагч байх
- "Хөдөлмөр, батлан хамгаалахад бэлэн" (ХБХБ) бүх Оросын биеийн тамир, спортын багц бэлтгэлийн алт, мөнгө, хүрэл тэмдэгтэй байх;
- ОХУ, төрлөөр Бүгд Найрамдах Саха (Якут) улсын аварга шалгаруулах тэмцээн, цом, тэргүүн байр шалгаруулах тэмцээний ялагч байх
- Бүгд Найрамдах Саха (Якут) улсын Үндэсний спортын төрлийн аварга шалгаруулах тэмцээний ялагч байх
- Сайн дурын ажил. Тус дээд сургууль нь сайн дурын ажлын туршлагыг нэмэлт оноо олгож харгалзан үздэг



Бакалавр, специалитет
ба магистрын хөтөлбөрт
суралцахаар **элсэх журам**

ЭЛСЭЛТИЙН КОМИСС

Хариуцсан нарийн бичиг

Оконешникова Мария Яковлевна

+7 914 300-84-44

pk@chgifikis.ru

ОЛИМПИЙН СПОРТЫН ТӨРЛҮҮД

- Чөлөөт бөх
- Бокс
- Байт харваа
- Теннис
- Буудлага
- Хөнгөн атлетик

ОЛИМПИЙН БУС СПОРТЫН ТӨРЛҮҮД

- Хапсагай
- Мас-реслинг
- Үндэсний харайлт
- Хойд зүгийн олон төрөлт тэмцээн

**ОРОС ХЭЛ СУРАХ**

Гадаад оюутнуудад орос хэл сурах хэцүү байдаг. Ингэхэд олон бэрхшээл тулгардаг бөгөөд энэ нь чөлөөтэй харилцахад ноцтой саад болдог. Олон хувилбарт байдал, олон тооны ижил утгатай үгс, үгсийн болон өгүүлбэрийн бүтцийн олон янз байдал.

Ном унших нь дүрмийн болон үгсийн шинж чанартай ихэнх хэлний бэрхшээлийг даван туулахад тус болдог. Алдаа гаргахаас айхгүй харьцах нь аман харилцааг тогтоож, өөртөө итгэлтэй болоход тусалдаг.



Чурапчагийн улсын биеийн тамир, спортын дээд сургууль нь биеийн тамир, спортын өндөр чанартай мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилгоор хамгийн идэвхтэй бөгөөд спортлог залуучуудыг нэгтгэсэн.

1 000 оюутан – шилдэг оюутнууд, идэвхтнүүд, сайн дурын ажилтнууд, спортын одод – энэ бүгд БИД!

ХҮРЭЛЦЭН ИРЭХ БА ДАСАН ЗОХИЦОХ

Тус дээд сургууль нь гадаадын бүх оюутнуудыг хөтлөн дагуулж, тэдэнд дэмжлэг үзүүлдэг. Оюутан бүрт түүнийг хариуцсан кураторыг томилдог.

Бүх оюутнуудыг дотуур байраар хангадаг.

ДЭД БҮТЭЦ

- Оюутны байр
- Сургалт-лабораторийн байр
- Байт харвааны талбайтай стадион
- Хөнгөн атлетикийн талбай
- Бөхийн танхим
- Орчин үеийн стандартад нийцсэн материал, техникийн суурь бааз
- Сургалтны ба бэлтгэлийн байр нь орчин үеийн технологич тоног төхөөрөмж ба материал хэрэгслээр тоноглогдсон



«Иван Ярыгин – 2023» Чөлөт бөхийн Гран-при олон улсын тэмцээн



АЛДАРТАЙ ТӨГСӨГЧИД

**Виталий Корякин**

ОХУ-ын чөлөөт бөхийн спортын мастер, Тажикистаны олон улсын спортын мастер, Оросын оюутны аварга (2005), Бээжингийн XXIX Олимпийн наадмын оролцогч (2008), чөлөөт бөхийн олон тооны олон улсын тэмцээний аварга, шагналт байрын эзэн.

**Николай Аянитов (Ноев)**

ОХУ-ын чөлөөт бөхийн спортын мастер, Оросын өсвөр насны аварга (2006), Их Британийн Лондоны XXX Олимпийн наадмын оролцогч (2012), И.Ярыгины олон улсын Гран-при тэмцээний шагналт байрын эзэн (2014), олон улсын ба оросын олон тооны тэмцээний аварга, шагналт байрын эзэн.

**Сардана Трофимова**

Тамирчин, олон улсын спортын мастер (хөнгөн атлетик), марафон гүйлтийн Оросын таван удаагийн аварга. Марафон гүйлтийн хувийн дээд амжилтаа 2014 онд тогтоосон – 2 цаг 24 минут 28 секунд.

**Василий Егоров**

Оросын сонирхогч боксчин, Якутын уугуул иргэн. 49 кг-ын жингийн Европын хошой аварга (2015, 2017), дэлхийн аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медалийн эзэн (2015). Оросын таван удаагийн аварга. Дэлхийн оюутны аварга (2014). Рио-де-Жанейрогийн XXXI Олимпийн наадмын оролцогч (2016).





БҮГД НАЙРАМДАХ САХА (ЯКУТ) УЛСЫН ХӨГЖМИЙН ДЭЭД СУРГУУЛЬ

Үүсгэн байгуулагдсан он – 1992

8

тэнхим

102

оюутан

2

Өмнөд Солонгосын 2 оюутан

ЯАГААД ХДС ГЭЖ?

- Оросын хөгжмийн боловсролын шилдэг уламжлал
- Экологийн цэвэр, байгалийн үзэсгэлэнтэй бүсэд байрлах оюутны хотхонд суралцах ба амьдрах нь бүтээлч уур амьсгалыг бий болгох ба хөгжүүлэхэд тус болдог
- Оросын тэргүүлэгч хөгжмийн их дээд сургуулиудын багш нарын мастер сургалтууд
- ХДС-ийн төгсөгчдийн ажлын байртай болох хувь өндөр байдаг

Хөгжмийн дээд сургууль (ХДС) бол Оросын Алс Дорнодын мэргэжлийн хөгжмийн боловсрол олгодог олон шатлалттай тогтолцоо бүхий цорын ганц боловсролын байгууллага юм.

Гадаад оюутнууд хичээлийн эхний өдрөөсөө эхлэн концерт, соён гэгээрлийн үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаж, хүүхэд залуучуудын филармонийн уран бүтээлийн хамтлагуудын гишүүн болдог.

 Сургалт орос хэл дээр явагддаг.

Жилийн сургалтын төлбөр
280 000 RUB*



*Сургалтын төлбөр ба оюутны хотхонд амьдрах зардал багтсан

Төгсөгчид Оросын соёл, урлагийн байгууллагуудад ажиллахаас гадна мөн Герман, Энэтхэг, Өмнөд Солонгос, Хятад, Грек, Марокко, Чили зэрэг улс орнуудын тэргүүлэх оркеструудын амжилттай гоцлол дуучид, уран бүтээлчид, концертмейстерууд болдог.



Оюутнуудын 70% нь Якутын симфони найрал хөгжмийн тоглогч болж, ХДС-ийг төгсөхөөсөө өмнө багш ба концертмейстер болж ажилладаг.

📍 Орос, Бүгд Найрамдах Саха (Якут) улс, Якутск

КОНЦЕРТЫН ТОГЛОЛТЫН УРЛАГ

- Төгөлдөр хуур
- Концертын чавхдаст хөгжмийн зэмсэг (хийл, эрдүү хийл, морин хийл, босоо ятга, контрабас)
- Концертын үлээвэр болон цохивор хөгжмийн зэмсэг (флейт, гобой, кларнет, фагот, саксофон, бүрээ, тромбон, валторн, туба)

Сургалтын хугацаа: 5 жил**Мэргэжил:** Концертын жүжигчин. Багш**ХӨГЖИМ-ТЕАТРЫН УРЛАГ**

- Дуурийн дууны урлаг

Сургалтын хугацаа: 5 жил**Мэргэжил:** Гоцлол дуучин. Багш**ЭЛСЭЛТ**




Специалитетын хөтөлбөрийн сургалтын элсэлтийг мэргэжлийн дунд болон дээд боловсролын суурь дээр явуулдаг.

Элсэлтийг шалгаруулалтын журмаар явуулна. Шалгаруулалтын сорилтууд:


- Бүтээлч сорилт (гоцлол хөтөлбөр)
- Мэргэжлийн сорилт (гармони, сольфежио)
- Ярилцлага
- Орос хэл
- Уран зохиол


Элсэлтийн шалгалтыг зайнаас өгөх боломжтой байдаг.



 vschoolmus.ru
 vk.com/vschoolmus
 youtube.com/
 @user-hi7kf9nf8u

ЭЛСЭЛТИЙН КОМИСС

 +7 4112 316-003

 vshkolamus@mail.ru – «Элсэлтийн комисст» гэж тэмдэглэнэ

ХДС-ийн оюутны хотхон нь Якутск хотоос 16 километрийн зайтай ойн бүсэд байрладаг. Оюутны хотхон нь шаардлагатай бүх дэд бүтэц бүхий 52 байгууламжаас бүрддэг бөгөөд энэ нь зөвхөн боловсролын үйл ажиллагааны хэрэгцээг хангахаас гадна оюутнуудын тав тухтай амьдрал, хооллолт, эрүүл мэндийг дэмжих таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

**БЭЛТГЭЛ АНГИ**

ТРКИ-1 (В1 түвшин) гэрчилгээгүй элсэгчид түнш байгууллагуудын бэлтгэл ангийн сургалтад хамрагдах боломжтой.

Тус ангид:

- "Орос хэлийг гадаад хэл болгон сурах" (ТРКИ-1 түвшинтэй болох)
- Мэргэжлийн дагуу ганцаарчилсан хичээлүүд
- Хөгжмийн онолын хичээлийн бүлэг ангиуд

Сургалтын хугацаа – 1 жил**Сургалтын төлбөр 150 000 RUB-ээс эхэлнэ**



БАЙГАЛИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Үүсгэн байгуулагдсан он - 1930

117

үндсэн
боловсролын
хөтөлбөр

30

бакалаврын
чиглэл

25

магистрын чиглэл

6

специалитетын
чиглэл

11

аспирантурын
чиглэл

13

лаборатори

16 000

оюутан

500

гадаад оюутан

300

аспирант

3

диссертацийн
зөвлөл

12

шинжлэх ухааны
сэтгүүл



Виртуал аялал

Өнөөдөр Байгалийн улсын их сургууль бол хууль зүй, эдийн засаг, удирдлагын чиглэлээр Оросын хамгийн хүчирхэг их сургуулиудын нэг юм. БУИС нь Оросын эдийн засгийн, хууль зүйн их сургуулиудын шилдгүүдийн тоонд, тухайлбал төгсөгчдийн цалингийн хэмжээгээр ТОП их сургуулиудын тоонд багтдаг. Монгол элсэгчдийн хувьд тус сургууль маш их алдартай.

БУИС-ийн төгсөгчид оросын болон олон улсын хөдөлмөрийн зах зээлд маш эрэлттэй байдаг. БУИС-ийн бизнесийн үндсэн түншүүд гэвэл оросын болон олон улсын ажил олгогч байгууллагууд, мөн орон нутгийн, бүс нутгийн болон холбооны түвшний захиргааны байгууллагууд юм.

Жилийн сургалтын төлбөр

1 500-1 700 USD



Сургалтын төлбөрийг жилээр ба хагас жилээр хийх боломжтой



bgu.ru
t.me/tg_bgu
vk.com/vkbaikalgu
youtube.com/@BaikalGU

📍 Орос, Эрхүү муж, Эрхүү хот

ХОС ДИПЛОМЫН ХӨТӨЛБӨРҮҮД

- «Хэл судлал», «Эдийн засаг», «Менежмент», «Худалдааны ажил»
 - Шэньяны Политехникийн их сургууль, БНХАУ 🇨🇳
 - Гадаад эдийн засаг, худалдааны их сургууль, БНХАУ 🇨🇳
 - Манжуурын орос хэлний дээд сургууль, БНХАУ 🇨🇳
- Англи хэлтэй магистрын хөтөлбөр «International management»

Монгол элсэгчдийн дунд хамгийн эрэлттэй чиглэлүүд

- Эдийн засаг
- Гааль
- Банкны ажил
- Олон улсын харилцаа
- Хууль зүй

БУИС нь Хятад 🇨🇳, Монгол 🇮🇪, Герман 🇩🇪, Франц 🇫🇷, Австри 🇦🇹, Африк, ТУХН-ийн улс орнуудын 50 гаруй их сургуультай хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна.

ОЛОН УЛСЫН ХОЛБООД

- Еврази-Номхон далайн их сургуулиудын холбоо
- Торгоны замын их сургуулиудын холбоо
- Орос-Хятадын эдийн засгийн их сургуулиудын холбоо г.м.

ОЛОН УЛСЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

Елена Витальевна Тихонова,
хэлтсийн дарга

☎ +7 3952 5-0000-8, нэмэлт дугаар 129

✉ TikhonovaEV@bgu.ru

✉ umd@bgu.ru





ДЭД БҮТЭЦ

- Эрхүү хотын түүхэн төв хэсэгт байрлах орчин үеийн оюутны хотхон
- 4 тохилог оюутны байр
- өөрийн кино театр, "Художественный" соёл, амралтын төв
- 12 шинжлэх ухааны сэтгүүл
- БУИС медиа төв – 24 цагийн турш цацагддаг оюутны телевиз, радио бүхий төсөл
- Спорт цогцолбор



Их сургууль нь Дэлхийн өвд бүртгэгдсэн Байгаль нууртай ойрхон байрладаг. Оюутны хотхон нь Эрхүү хотын түүхэн төв хэсэгт буюу гол үзэх газруудад алхаад очих зайд байрладаг.



ШИНЖЛЭХ УХААНЫ ЧИГЛЭЛҮҮД

- Улсыг орлого бүрдүүлэлтийн асуудал
- Макро эдийн засгийн таамаглал, зохицуулалт
- Байгалийн нөөцийн ашиглалтын эдийн засаг, менежмент
- Эрүүгийн байцаан шийтгэх ажил, криминологи, шүүхийн шинжилгээ

Хичээл, спорт, нийгэм, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан оюутнууд их сургуулийн болон төрийн бус төрөл бүрийн тэтгэлэгт хамрагдах боломжтой. Тэдгээрийн нэг нь 2019 онд байгуулагдсан Ю. Цэдэнбалын нэрэмжит тэтгэлэг юм.


МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ

Монгол судлаач мэргэжилтнүүдийн бэлтгэл.

Одоогоор тус төв нь **“Дэлхийн болон Оросын Монгол судлал: үндэсний дэг сургууль, үзэл баримтлал, судлаачид”** сэдвээр Оросын Шинжлэх ухааны сангийн грантыг хэрэгжүүлж байна. Монголын талаас төслийн шинжлэх ухааны удирдагчаар МУБИС-ийн хүндэт профессор Жамсрангийн Урангуа ажиллаж байна.

Орос болон дэлхийн Монгол судлалын түүхэнд анх удаа дэлхийн Монгол судлалын түүх болон өнөөгийн байдалд зориулсан гурван боть номыг бэлтгэж байна.

Тус төслийг их сургуулийн эрдэмтдийн оролцоотой хэрэгжүүлж буй нь Байгалийн их сургуулийн Монгол судлалын чиглэлийн олон улсын шинжлэх ухааны нэр хүндийг хүлээн зөвшөөрч, Эрхүү хотын дэлхийн монгол судлалын нэгэн төв болох үүргийг баталгаажуулах боломжийг олгож байна.



Байгалийн их сургууль нь Монголын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх салбарын анхдагч сургууль юм.

Нийт 90 гаруй жилийн түүхэндээ БУИС нь 2 000 гаруй мэргэжлийн өндөр түвшний боловсон хүчин, түүний дотор аспирант, докторантууд бэлдсэн юм.

Юмжаагийн Цэдэнбал. БУИС-ийн анхны төгсөгчдийн нэг (1938), Монгол Ардын Хувьсгалт Намын Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын маршал.

Хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэх, Монголын удирдагчдыг бэлтгэх ажилд гарамгай гавьяа зүтгэл гаргасны төлөө БУИС-ийг 1972 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, 2007 онд Ю.Цэдэнбалын алтан одонгоор тус тус шагнасан.



Гомбожавын Занданшатар, Монгол Улсын Их Хурлын дарга, БУИС-ийн 1992 оны төгсөгч

Байгалийн их сургуулийн төгсөгчид улсын хөгжлийн гол нөөцийн нэг юм. Тэд эрэлттэй байдаг бөгөөд олон салбаруудад тэргүүлэх байр суурийг эзэлдэг. Өнгөрсөн жилүүдэд БУИС-ийн 10 төгсөгч Монгол Улсын Сангийн сайдаар, 5 төгсөгч Төв банкны даргаар ажиллаж байсан. Байгалийн улсын их сургууль нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Орос-Монголын хамтын ажиллагаа, найрсаг харилцааг хөгжүүлэх холбогч байсаар ирсэн.



БУРЯТСКИЙ ГОСУДАРСТВЕННЫЙ
УНИВЕРСИТЕТ
ИМЕНИ ДОРЖИ БАНЗАРОВА

БГУ - 90 лет

БГУ - 90 лет



ДОРЖИ БАНЗАРОВЫН НЭРЭМЖИТ БУРИАДЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Үүсгэн байгуулагдсан он – 1932

91

Бакалаврын
91 хөтөлбөр

2

Специалитетын
2 хөтөлбөр

43

Магистрын
43 хөтөлбөр

9

Ординатурын
9 хөтөлбөр

38

Аспирантурын
38 хөтөлбөр

8 000+

оюутан

250+

Дэлхийн 20 улс
орны 250+ гадаад
оюутан



RAEX Алс Дорнодын
Холбооны тойргийн Их дээд
сургуулиудын шилдэг гуравт
багтсан

Буриадын Улсын их сургууль бол Алс Дорнодын томоохон их сургуулиудын нэг юм. БУИС нь төрөл бүрийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх тэргүүлэх мэргэшсэн сургалтын төвүүдийн нэг юм.

Жилийн сургалтын төлбөр

Бакалавр, специалитет
144 000 – 195 000 RUB

Магистр 155 000 – 209 000 RUB

Аспирантур 182 000 – 212 000 RUB

Ординатур 232 000 RUB



Доржи Банзаровын нэрэмжит Буриадын Улсын их сургуулийн нэр хүндтэй диплом гардаж авсан мэргэжилтнүүд гарааны ашигтай байр суурьтай болж, Оросын олон бүс нутгуудад ажиллаж, гадаадын улс орнуудад эрэлттэй байдаг.

Сургалтын төлбөрийн 20% хүртэл хямдралын уян хатан тогтолцоо



bsu.ru



vk.com/bsu03



t.me/bsulite



dzen.ru/bsu



rutube.ru/channel/23337819

БУИС – Чиний амьдралын төв



Орос, Бүгд Найрамдах Буриад Улс, Улаан-Үд

СУРГАЛТЫН ЭРЭЛТТЭЙ ХӨТӨЛБӨРҮҮД

Техникийн чиглэлийн үйлдвэрийн дадлага нь их сургуулийн бодит түнш байгууллагуудад явагддаг бөгөөд залуус өөрсдийн мэргэжлийн нарийн зүйлсийг сурч, ихэнхдээ энэ үе шатанд ажилд ордог. Ихэнх тохиолдолд төгсөж буй бакалавр нь аль хэдийн салбарынхаа бэлэн мэргэжилтэн болсон байдаг!

МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН МАТЕМАТИКИЙН ХАНГАМЖ, УДИРДЛАГА

мэргэжил Мэдээллийн систем ба мэдээллийн сан

Тус чиглэлийн төгсөгчид математикийн суурь боловсролтой болдог, төрөлжсөн мэргэжлийн хичээлийг бүс нутгийн мэдээллийн технологийн тэргүүлэх мэргэжилтнүүд заадаг.

ХЭЛ ШИНЖЛЭЛ. ОРЧУУЛГА, ОРЧУУЛГА СУДЛАЛ

БУИС-ийн хэл судлал, гадаад хэл, олон нийтийн харилцааны хүрээлэн нь их сургуулиас гадна цууриатсан алдар нэртэй. Энд мэргэжлийн орчуулагчдыг бэлтгэдэг!

ХУУЛЬ ЗҮЙ

БУИС-ийн хуульчид бүс нутгийн хамгийн шилдгээр зүй ёсоор тооцогддог!

Олон төгсөгчид сургалтын үйл явцыг ажилтай хослуулан магистрт үргэлжлүүлэн суралцдаг. Үүнд сургалтын уян хатан хуваарь тус болдог.

ДОРНО ДАХИНЫ СУДЛАЛ, АФРИК СУДЛАЛ

Сургалтын хөтөлбөр:

- Дорно дахины хэлүүд (Хятад, Солонгос, Япон, Монгол) болон уран зохиол
- Ази, Африкийн улс орнуудын түүх
- Ази, Африкийн улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжил
- Гадаад бүс нутгийн судлал
- Аялал жуулчлал

Дорно дахины хүрээлэн нь сүлжээний хөтөлбөр ба солилцооны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Оюутнууд судлаж буй хэлийнхээ оронд зочлохоос гадна тэнд дадлага хийх, хэрэв хүсвэл цаашид магистрын хөтөлбөрт хамрагдах боломжтой.

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛ

Оюутнууд Улаан-Үдийн эрүүл мэндийн байгууллагуудад дадлага хийдэг бөгөөд тэнд туршлагатай багш нарын удирдлаган дор ийм өндөр хариуцлагатай, чухал мэргэжлийн шаардлагатай ур чадваруудыг эзэмшдэг.

ЭЛСЭГЧИЙН ГАЙД

1

Их сургуулийн сайтын «Элсэгчдэд» хэсгээс сургалтын чиглэлээ сонгоно уу.



2

Дараах гурван аргын нэгээр элсэлтийн бичиг баримтаа илгээнэ үү:

- Биечлэн, хаяг: 📍 Бүгд Найрамдах Буриад Улс, Улаан-Үд хот, Смолина гудамж, 24А, 0105 өрөө
- Төрийн үйлчилгээний сайтын «Хүүхдүүд Боловсрол» хэсгээр
- Элсэгчийн хувийн танхимаар



ОЛИМПИАД

«Байгаль нуурын ирээдүй»

9-11-р ангийн сурагчдад зориулсан дунд сургуулийн сурагчдын олимпиад

Эцсийн шатны ялагчид ба шагналт байр эзэлсэн сурагчид элсэх үедээ нэмэлт оноо авч, сургалтын зардлын 30%-ийн грант авдаг.



Байгалийн ба шинжлэх ухааны тэнхимийн элсэгчдэд зориулсан математикийн олимпиад

Ялагчид болон шагналт байр эзэлсэн сурагчид үнэ цэнэтэй шагнал хүртдэг.

ЭЛСЭЛТИЙН ТАЛААР АСУУХ ЗҮЙЛ ГАРВАЛ

☎ +7 3012 22-77-22 шууд утас
5:00 – 12:00 MSK, олон сувагтай утас

Олон улсын харилцааны хэлтэс

☎ +7 3012 21-18-64
✉ intdep@bsu.ru

Элсэлтийн комисс

✉ udp@bsu.ru



ИХ СУРГУУЛИЙН ОНЦГОЙ БАЙРШИЛ

Манай их сургууль Бүгд Найрамдах Буриад улсын нарлаг нийслэл Улаан-Үд хотод, дэлхийн хамгийн эртний усан сангуудын нэг, дэлхийн цэвэр усны тавны нэгийг агуулдаг Байгаль нуураас хоёр цагийн зайд байрладаг.

Байгаль нуур болон түүний нуурын эрэг орчмын бус нутаг нь давтагдашгүй ургамал, амьтны аймгаар баялаг байдаг бөгөөд энэ нь тус нутгийг үнэхээр онцгой болгож, шинжлэх ухааны судлаачид, олон тооны аялал жуулчлал ба адал явдал сонирхогчдын анхаарлыг байнга татдаг.

ОЮУТНЫ БАЙР

Их сургууль нь өдрийн ангийн оюутнуудыг оюутны байраар хангадаг.

Сарын төлбөр 850 – 3 100 RUB

Дундаж зардал:

- 1 өрөө байр түрээслэхэд сарын төлбөр 15 000 RUB-с эхэлнэ
- Цайны газрын өдрийн хоол – 100 RUB-с эхэлнэ
- Кафед өдрийн хоол – 200 RUB-с эхэлнэ

ДАВУУ ТАЛУУД

- Шинжлэх ухааны судалгааны ба инновацийн үйл ажиллагаа, хэрэглээний шинжлэх ухааны судалгааны хөгжил
- Орчин үеийн сургалтын дэд бүтэц
- Хичээлээс гадуурх үйл ажиллагааны систем нь олон тооны биеийн тамирын, уран бүтээлийн ба шинжлэх ухааны оюутны холбоог багтаадаг

2024 онд Улаан-Үд хотод боловсролыг хөгжүүлэх шинжлэх ухааны төв болох их дээд сургууль хоорондын оюутны хотхоны барилгын эхний үе шатны ажил эхлэх бөгөөд тэнд Монгол 🇮🇾, Хятадын 🇨🇳 гадаад оюутнуудад орос хэл заахаар төлөвлөж байна.

Оюутны хотхоны төсөлд дараах зүйлс багтана:

- Сургалтын лабораторийн байрууд
- 2500 хүний дотуур байр



Дэлхийн ард түмнүүдийн үндэсний хоол

ХҮРЭЛЦЭН ИРЭХ БА ДАСАН ЗОХИЦОХ

Буриадын Улсын их сургуульд өдөр тутмын төрөл бүрийн асуудлыг шийдвэрлэхэд зөвлөх багш болон сайн дурын ажилтнууд туслах тогтолцоо ажилладаг.

Олон улсын харилцааны хэлтсийн ажилтнууд шинэ оюутнуудыг нисэх онгоцны буудал, төмөр замын буудал дээр угтаж авахаас гадна элсэлтийн комисс ба банкинд хандах, дотуур байранд орох, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, мөн шилжилт хөдөлгөөний албанд хандах үед тэдэнд туслалцаа үзүүлдэг.

🇮🇾 🇨🇳 ОРОС-МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бүгд Найрамдах Буриад Улсын Засгийн газрын грантаар «Орос хэлийг гадаад хэлээр судлах» бэлтгэл сургалтын хөтөлбөрийн хүрээнд монгол оюутнуудын сургалтын зардлыг санхүүжүүлдэг. Тус сургалтын хөтөлбөрийн төгсөгчид Монголд орос хэл, уран зохиолын багшаар ажиллах боломжтой.



Грант авах хүсэлт гаргах





ВЯТКАГИЙН УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

СКИЙ УНИВЕРСИТЕТ

Үүсгэн байгуулагдсан он – 1930

23

бакалаврын хөтөлбөр

3

специалитетын хөтөлбөр

16

магистрын хөтөлбөр

11

аспирантурын хөтөлбөр

15

коллежийн хөтөлбөр (МДБ)

5

факультет

20

тэнхим

3 624

оюутан, тэдний дунд дэлхийн 13 улсын гадаад оюутан

Вяткагийн улсын хөдөө аж ахуйн технологийн их сургууль нь агроном, биологи, мал судлал, мал эмнэлэг, хөдөө аж ахуйн инженер, эдийн засгийн чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг.

Тус их сургууль нь оюутнууд болон төгсөгчдийн дадлага хийх, цаашид ажлын байр болох Оросын Холбооны Улсын хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн цогцолборын томоохон аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилладаг.



vgatu.ru

t.me/vgatu1930

vk.com/info.vgsha

vk.com/international_department_vgatu



**Жилийн сургалтын төлбөр
Өдрийн анги**

**Бакалавр 120 000 – 140 000 RUB
Магистр 122 000 – 148 000 RUB
Специалитет 120 000 – 140 000 RUB
Аспирантур 149 000 – 159 000 RUB**



30

Хөдөө аж ахуйн их сургуулиудын их сургуулиудын дунд

4

Ижил Мөрний Холбооны тойргийн хөдөө аж ахуйн их сургуулиудын дунд



Орос, Киров муж, Киров

ЭЛСЭЛТ

Бичиг баримт хүлээн авах ажил ба элсэлтийн шалгалт **6-р сарын 20-оос 8-р сарын 19 хүртэл** үргэлжлэнэ.

Элсэлтийн шалгалт нь биечлэн ба цахим хэлбэрээр явагдана:

- **бакалаврын хөтөлбөрт:** гурван хичээлийн шалгалт
- **магистрын хөтөлбөрт:** бэлтгэлийн зохих чиглэлээр тест явуулна
- **аспирантурын хөтөлбөрт:** тусгай хичээлийн шалгалт

Бакалавр, магистр, аспирантурын боловсролын хөтөлбөрөөр суралцах боломжит хувилбарууд:

- төлбөртэй сургалтын гэрээний дагуу
- Оросын Холбооны Улсын квотын дагуу



ЭЛСЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЗААВАР

- 1 Бичиг баримтаа бэлдээд,
✉ priem@vgatu.ru хаяг руу илгээнэ үү
 - гадаад паспорт, нотариатаар баталгаажуулсан орчуулгын хамт
 - боловсролын бичиг баримт ба дүнгийн хавсралт, нотариатаар баталгаажуулсан орчуулгын хамт
 - гадаадын боловсролыг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ (шаардлагатай бол)
 - зураг 3x4 см
 - зорилго тодорхойлсон эссэ (магистр, аспирантурт элсэхэд)
 - нийтлэлийн жагсаалт (аспирантурт элсэхэд)
- 2 Элсэлтийн шалгалт өгнө үү
- 3 Их сургуулиасаа урилга хүлээн авч, Орос руу нэвтрэх сургалтын виз авна уу
- 4 Хүрэлцэн ирэх огноогоо мэдэгдэнэ үү

ЭЛСЭЛТИЙН КОМИСС

Дарга
Потураева Екатерина Руслановна

✉ priem@vgatu.ru





БЭЛТГЭЛ АНГИ

"Гадаадын иргэд, иргэний харьяалалгүй хүмүүсийг орос хэлний мэргэжлийн боловсролын хөтөлбөрийг эзэмшихэд бэлтгэх" хөтөлбөр.

Сургалтын төлбөр:

Жилийн 100 000 – 125 000 RUB

Сургалтын хөтөлбөр нь гурван

түвшинтэй: анхан шатны, суурь, гүнзгийрүүлсэн. Түүнээс гадна, сурагчид Оросын Холбооны Улсын их дээд сургуульд элсэхэд шаардлагатай гурван хичээлээс сонголт хийх боломжтой.

Бэлтгэл ангийн сурагчдад зориулж Киров хот болон бүс нутгийн музей, үзэсгэлэнт газруудад боловсролын болон сэдэвчилсэн аялал зохион байгуулдаг. 2020 оноос эхлэн Олон улсын залуучуудын өдрийг тохиолдуулан **«Оюутны идэвхийн зуны сургууль»** хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон төрлийн зугаа цэнгэлийн ба танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулдаг.

ОРОС ХЭЛ СУРЖ БУЙ ХҮМҮҮСТ ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Сургалтын эхлэл үеийн хамгийн хэцүү зүйл бол **бичгийн хэл** юм.

- Авиа зүй, зөв бичгийн дүрэмд онцгой анхаарах хэрэгтэй, учир нь унших, ярих, дүрэм, үг хэллэг сурахад бичгийн хэл нь чухал туслах үүрэг гүйцэтгэдэг
- Аман яриаг тогтоон цээжлэж сур:
 - Орос хэлтэй ном унш
 - Орос хөгжим сонс
 - Орос кино үз
- Хичээлийнхээ эхнээс шууд орос хэлээр ярьж эхлэх нь чухал. Алдаа гаргахаас бүү ай: хүн бүр алдаа гаргадаг!
- Таныг оросоор ярихыг хичээж байгааг багш тань үнэлж, Таныг ойлгохыг хичээх болно
- Орост ирж орос хэлний дадлага хий

Орос хэл сурах бүх үе шатанд бичих ба ярих чадвараа тасралтгүй сайжруулж байх нь чухал юм.

МАЛ АЖ АХУЙ**бакалавр****Мэргэжил – Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи**

Тус хөтөлбөр нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн чиглэлээр мал судлалын бакалаврын мэргэжилтнүүдийг бэлтгэдэг. Хөтөлбөрийг төгсөгч нь мал тэжээх, үржүүлэх, амьтны гаралтай бүтээгдэхүүн боловсруулах технологийн чиглэлээр орчин үеийн арга ба технологийг ашиглах мэдлэгтэй болно.

Мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлүүд:

- үйлдвэрлэл, технологийн
- зохион байгуулалт, удирдлагын
- шинжлэх ухаан, судалгааны

Оюутнууд Киров мужийн тэргүүлэх аж ахуйн газрууд болон шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагуудад дадлага хийдэг.

Боловсролын хөтөлбөрийг эзэмших явцад оюутнууд компьютерийн программын тусламжтайгаар хооллолтын хуваарь боловсруулж, “Селекс”, “Фиас”, “Гибрид” зэрэг программуудыг ашиглан мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөж, удирдаж сурдаг.

Төгсөгчид сүү, мах үйлдвэрлэх ферм болон аж үйлдвэрийн цогцолбор, мал үржлийн үйлдвэр, мал үржүүлгийн нөхөн үржихүйн газар, малын селекц, эрлийз үржлийн төв, амьтны гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, тэжээл ба нэмэлт тэжээл үйлдвэрлэх аж ахуйн нэгж байгууллагуудад ажилладаг.

Сургалтын жилийн төлбөр:**140 000 RUB****Сургалтын хэл:** орос **ХҮРЭЛЦЭН ИРЭХ, ДАСАН ЗОХИЦОХ**

Их сургуулийн ажилтнууд гадаадын элсэгч оюутан бүрийг тосон авч, хөтлөн дагуулдаг. Тэд оршин суух газрын дагуу бүртгэл хийлгэх, эрүүл мэндийн даатгал авах, оюутны байранд нүүж ороход дэмжлэг, туслалцаа үзүүлдэг.

Вяткагийн УХААТИС-д залуучуудын бодлогод ихээхэн анхаарал тавьж ажилладаг бөгөөд тус бодлогын гол зорилго нь мэргэжлийн өндөр түвшний, өрсөлдөх чадвартай боловсон хүчин бэлдэхээс гадна амьдралын эрүүл хэв маягтай, нийгмийн хариуцлагатай, бүтээлч хувь хүнийг төлөвшүүлэх явдалд оршдог. Бүх гадаад оюутнууд шинжлэх ухаан, уран бүтээл, чөлөөт цагийн үйл ажиллагаа явуулах өргөн боломжтой байдаг: шинжлэх ухааны төсөл хэрэгжүүлэх, төрөл бүрийн түвшний эрдэм шинжилгээний бага хуралд оролцох, спортын арга хэмжээнд оролцох, сайн дурын ажил хийх, их сургуулийн театр ба бүжгийн үзүүлбэр тавих гэх мэт.



Төсвийн зардлаар суралцдаг бөгөөд шалгалтуудаа бүрэн өгсөн бүх гадаад оюутнууд сард 6 000-аас 10 000 RUB хүртэл хэмжээний тэтгэлэг авдаг.

Их сургуулийн олон улсын, соёл урлагийн, спортын арга хэмжээнд идэвхтэй оролцсоны төлөө өсгөсөн хэмжээний тэтгэлэг авах боломжтой.



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Үүсгэн байгуулагдсан он – 1779

8

факультет

27

тэнхим

600+

төсвийн зардлаар
суралцах эрх

Газар зохион байгуулалтын улсын их сургууль (ГЗБУИС) нь Оросын хамгийн эртний их сургуулиудын нэг юм. Тус их сургууль нь газар зохион байгуулалт, кадастр, хэрэглээний геодези, байгаль орчны ашиглалт, архитектур, хууль зүй, менежмент болон бусад чиглэлийн боловсон хүчин бэлтгэдэг.

Тус их сургууль нь Олон улсын геодезистийн холбоо (FIG), Олон улсын фотограмметр ба зайнаас тандан судлах нийгэмлэг (ISPRS), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (FAO) зэрэг олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.



Сургалтын төлбөрийг сайт дээр
танилцуулсан

Сургалтын хэлбэр: өдрийн, өдрийн эчнээ
хосолсон, эчнээ.

Боловсролын түвшнүүд: бакалавр, магистр,
аспирантур, докторантур.

📍 Орос, Москва

ДАВУУ ТАЛУУД

- Оросын тэргүүлэх хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн их сургуулийн диплом
- Байршил – Москва хотын төв
- Цаашид ажлын байраар хангах сургалтын болон үйлдвэрлэлийн дадлага
- ГЗБУИС-ийн оюутны байранд амьдрах боломж

Оросод газар зохион байгуулалт, кадастр, газрын мониторингийн чиглэлээр суралцаж буй гадаадын нийт иргэдийн 20 орчим хувь нь ГЗБУИС-ийн оюутнууд байдаг.

ЭЛСЭЛТ

 Беларусь,  Казахстан,  Киргиз,  Тажикстаны Бүгд Найрамдах улсын иргэд Оросын төсвийн зардлаар их сургуулийн бүх сургалтын хөтөлбөрт хамрагдах боломжтой. Бусад улсын иргэд сургалтын гэрээгээр суралцах боломжтой.

Шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг их сургуулийн сайтад байрлуулсан болно.



- www.guz.ru
- vk.com/guz_vuz
- t.me/fgbouvoguz

ЭЛСЭЛТИЙН КОМИСС

 +7 499 261-31-46

 info@guz.ru

Гадаадын элсэгчидтэй ажиллах мэргэжилтэн
Нелюбова Елена Михайловна

 +7 901 799-71-55

 e.neljubova@yandex.ru

 interdep@guz.ru

СУРГАЛТЫН ЧИГЛЭЛҮҮД

- Менежмент
- Газар зохион байгуулалт, кадастр
- Хэрэглээний геодези
- Экологи, байгаль орчны ашиглалт
- Техносферийн аюулгүй байдал
- Геодези, зайны тандан судалгаа
- Архитектур
- Дизайн
- Ландшафтын архитектур
- Хууль зүй



БЭЛТГЭЛ АНГИ

Бэлтгэл ангийн үндсэн үүрэг нь гадаадаас Оросод ирсэн ирээдүйн мэргэжилтнүүдийг боловсролын хөтөлбөрөөр үндсэн бэлтгэх явдал юм.

Мэргэжлийн чиглэл:

- анагаах ухаан, биологийн
- инженер, техникийн
- эдийн засгийн

Сургалтын хугацаа – хичээлийн 1 жил (2 семестр)

Гадаадын иргэдийн элсэлт бүтэн жилийн турш явагдана. 14 сурагчтай ангийг мэргэжлийн чиглэлийн бүлэг дүүргэх хүртэл бүрдүүлнэ.

Бэлтгэл ангийн боловсрол ба хүмүүжлийн үндсэн ажлыг олон жилийн ажлын туршлагатай РКИ-ийн мэргэжлийн өндөр түвшний багш нар хийж гүйцэтгэдэг. Багш нар ажилдаа хэл заах хамгийн сүүлийн үеийн арга зүй ашиглаж, сургалтын үргэлжлэх хугацаанаас хамааран сургалтын материал болон түүнийг танилцуулах арга замыг нухацтай сонгодог.

Хичээлийн жилийн төгсгөлд оюутнууд орос хэл ба сонгосон мэргэжлийн хичээлээр шалгалт өгдөг. Шалгалтаа амжилттай өгсний дараа оюутнууд их сургуулийн өмнөх бэлтгэл анги төгссөн гэрчилгээ авдаг. Энэ нь тэдэнд тус их сургууль эсвэл Оросын өөр их сургуульд сонгосон мэргэжлээрээ амжилттай үргэлжлүүлэн суралцах боломжийг олгодог.





1957 оноос хойш тус их сургууль 100 орчим монгол мэргэжилтэн бэлдэж, төгсгөсөн. ГЗБУИС-ийн бүх төгсгөгчид Монголд төрийн өндөр албан тушаал хашиж, төрөл бүрийн байгууллагын даргаар ажилладаг.



ОРШИН СУУХ

Гадаад оюутнуудыг оюутны байраар хангадаг. Оюутны байр нь хаалттай балкон бүхий 12 давхар угсармал барилга байдаг. Нийт 40 м² талбай бүхий орон сууцны блокууд нь шинэ засвар хийсэн 2 хүний хоёр өрөөтэй буюу нийт 4 хүний багтаамжтай.



“

**Хонаев Алтантан, Монгол Улс.
Архитектурын факультетын элсэгч**

Би 18 настай, ГЗБУИС-д боловсрол эзэмшихийн тулд Монголоос ирсэн. Одоо орос хэлний сургалтад сууж байна. Би архитектор болохыг хүсдэг.

Би Газар зохион байгуулалтын их сургуулийг Москва хотын төвд байрладаг, мөн баялаг түүх, уламжлалтай их сургууль учраас сонгосон. Оюутны байр нь нам гүм, тохилог, гэрэл гэгээтэй. Хүмүүс надад маш найрсаг ханддаг.



Жанлавын Наранцацралт (1957–2007). Газар зохион байгуулалтын их сургуулийн төгсөгч, түүний цээж баримал нь Их сургуулийн Алдрын гудамжинд байрладаг

Жанлавын Наранцацралт – Монголын нэрт улс төрч, Монгол Улсын 20 дахь Ерөнхий сайд (1998–1999), Улаанбаатар хотын захирагч (1996–1998), профессор, шинжлэх ухааны доктор.



МОСКВАГИЙН УЛСЫН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ «СТАНКИН»

ТВЕННЫЙ
ВЕРСИТЕТ

1930 онд үүсгэн байгуулагдсан

45

бакалаврын
хөтөлбөр

1

специалитетын
хөтөлбөр

53

магистрын
хөтөлбөр,
түүнчлэн англи
хэл дээр

17

аспирантурын
хөтөлбөр

5 000+

оюутан ба
аспирант

900+

дэлхийн 73 улсын
900+ гадаад
оюутан

Дижитал машин үйлдвэрлэлийн чиглэлээр тэргүүлэгч технологийн их сургууль, судалгааны хүчирхэг төв. Тус их сургууль нь сургалтын хөтөлбөрөө боловсруулахдаа хувьд хүнд чиглэсэн боловсролын чиглэл болон төслийн хандлага ашиглан онцгой мэргэжилтнүүдийг бэлтгэдэг.

Төгсөгчид нь эдийн засгийн өндөр технологийн салбарууд, томоохон үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд, мэдээллийн технологийн салбар, «Аж үйлдвэр 4.0» технологийг нэвтрүүлэхтэй холбоотой орчин үеийн дижитал төслүүдэд эрэлт ихтэй байдаг.

- stankin.ru
- vk.com/msut_stankin
- t.me/msutstankin
- rutube.ru/channel/23638548
- tiktok.com/@stankin_main



Нээлттэй
хаалганы
өдөрлөг



Сургалтын жилийн төлбөр

Бакалавр 229 700 – 273 700 RUB

Магистр 254 400 – 299 400 RUB

Аспирантур 291 000 – 317 100 RUB



Оросод 27



Оросод 54



Оросод 29
Инженер-
техникийн
салбар



241-250
дэлхийд



291-300
дэлхийд



56-58
17
Судалгаа

📍 Орос, Москва

ЭЛСЭЛТИЙН ОЛОН УЛСЫН ОЛИМПИАДУУД

«МОСТ»

Сургуулийн сурагчдын олон хичээлийн олимпиадууд

Бүх оролцогчид сургалтын нийт хугацаанд 10% хөнгөлөлт эдэлнэ.

Хичээлүүд: Орос хэл, математик, физик, хими, мэдээлэл зүй, нийгмийн ухаан.

«Миний мэргэжлийн замнал»


Магистрын ангид элсэж буй элсэгчдэд зориулсан олон хичээлийн олимпиадууд


Түрүүлсэн оюутнууд холбооны төсвийн зардлаар магистрын боловсрол эзэмших эрхтэй болно.


Бүх оролцогчид сургалтын нийт хугацаанд 10% хөнгөлөлт эдэлнэ.

 mycareer.stankin.ru

ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

 Орос хэл дээр явагддаг сургалтын хөтөлбөрүүдэд элсэхдээ гадаадын оюутнууд математик ба орос хэлний шалгалт өгнө

 Англи хэл дээр явагддаг сургалтын хөтөлбөрүүдэд элсэхдээ англи хэл дээр ярилцлага өгнө



Элсэх өргөдөл
гаргах

**Олон улсын хамтын ажиллагааны
төвийн захирал**

Надежда Юльевна Попова

 +7 499 972-94-11, +7 499 973-39-66

 inter@stankin.ru

 welcome@stankin.ru

 n.popova@stankin.ru



«СТАНКИН» МУТИС-ийн олимпиадууд

ЭЛСЭЛТИЙН БИЧИГ БАРИМТ

- Элсэгчийн иргэний үнэмлэх
- ОХУ-тай визтэй зорчих орнуудын хувьд эхлээд виз мэдүүлэх шаардлагатай
- Боловсролын түвшин ба (эсвэл) мэргэшлийн тухай гадаад улсын баримт бичгийн эх хувь (эсвэл зохих ёсоор баталгаажуулсан хуулбар), түүний хавсралт
- Боловсролын түвшин ба (эсвэл) мэргэшлийн тухай гадаад улсын баримт бичиг, түүний хавсралтын орос хэл рүү хийсэн орчуулга
- Их сургуульд суралцахад эсрэг заалт байхгүй болохыг баталгаажуулсан эрүүл мэндийн бичиг баримт, тогтоосон маягтын дагуу
- 6 зураг (матт өнгийн, 3×4 см) болон 6 зураг (матт өнгийн, 2×3 см)
- Сургалтын төлбөр, байр (1 жилийн хугацаатай), эрүүл мэндийн даатгалын зардлыг төлөхөд хангалттай хэмжээний мөнгө

БЭЛТГЭЛ АНГИ

Орос хэл зааж, их сургуульд элсэхэд бэлдэнэ.

Төлбөр 65 000 – 250 000 RUB

Бэлтгэл ангийг амжилттай дүүргэсний дараа их сургуульд цаашид суралцахад хувь хүний хөнгөлөлт үзүүлэх боломжтой.



Бэлтгэл ангийн сурагчид

Сургалтын эрэлттэй чиглэлүүд	Бакалавр	Магистр	Аспирантур
Мэдээлэл зүй ба тооцооллын техник	✓	✓	✓
Програм хангамжийн инженерчлэл	✓	✓	
Багаж үйлдвэрлэл	✓	✓	
Машин үйлдвэрлэл	✓		✓
Технологийн процесс болон үйлдвэрлэлийн автоматжуулалт	✓	✓	
Машин үйлдвэрлэлийн зохион бүтээлт-технологийн дэмжлэг	✓	✓	
Мехатроник ба робот техник	✓	✓	
Техносферийн аюулгүй байдал	✓	✓	
Материалын шинжлэх ухаан ба материалын технологи	✓		
Чанарын менежмент	✓		
Техникийн системийн менежмент	✓		✓
Эдийн засаг	✓		✓
Менежмент	✓	✓	
Физик ба одон орон судлал			✓
Философи, ёс зүй ба шашин судлал			✓

ТЭТГЭЛЭГ

Их сургуулийн шинжлэх ухаан, нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, мэдлэгээ хөгжүүлэх онцгой чадварыг харуулсан оюутнуудад нэмэгдүүлсэн тэтгэлэг олгож, хувь хүний хөнгөлөлт үзүүлдэг.

ДАДЛАГА ХИЙХ БА АЖИЛД ОРОХ



Робот техник ба мехатроникийн лаборатори



Соёлын нэгдэл

“



Батдэлгэр Булгантамир, Монгол Улс. «Технологийн машин ба тоног төхөөрөмж» чиглэлийн бакалаврын 2-р курсын оюутан

«СТАНКИН» их сургуульд олон төрлийн инженерийн мэргэжлээр суралцах боломжтой. Орос хэл огт мэдэхгүй байх нь асуудал биш, их сургуульд гадаад оюутнуудад зориулсан орос хэлний 1 жилийн эрчимжүүлсэн сургалт байдаг.

Манай их сургуульд жинхэнэ мэргэжлийн өндөр чадвартай хүмүүс ажилладаг. Багш нар орос хэл, Оросын олон талт соёл ба түүхийг судлахад тусалдаг.

Би дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүстэй танилцсан. «СТАНКИН» их сургуульд суралцах нь надад үнэхээр таалагддаг.

“



Майбат Оюумаа, Монгол Улс. «Програм хангамжийн инженерчлэл» чиглэлийн бакалаврын 2-р курсын оюутан

Энэ их сургууль нь инженерийн чиглэлдээ тэргүүлэгч их сургууль учраас би «СТАНКИН» МУТИС-ийг сонгосон.

Орос хэл заахаас эхлээд энд сургалтын чанар маш өндөр байдаг. Багш нар амьдралын зорилгоо олоход бидэнд тусалдаг.

Их сургууль болон миний хичээл зүтгэлийн ачаар надад олон шинэ боломж бий болсон.

“



Нямдорж Хажидмаа, Монгол Улс. «Хүний нөөцийн менежмент» чиглэлийн магистрын 2-р курсын оюутан

Москвагийн их сургуулиудын дунд тэргүүлэх байр суурийг эзэлдэг учраас би СТАНКИН-ийг сонгосон.

Энэ жил би орос хэл сурсан. Өндөр ур чадвартай багш нартаа маш их талархаж байна.

Энэ их сургуульд миний олон найзууд суралцдаг бөгөөд тэдэнтэй хамт бид мэдлэг чадвараа дээшлүүлсээр байна.





И.М.ГУБКИНЫ НЭРЭМЖИТ ОРОСЫН ГАЗРЫН ТОС, БАЙГАЛИЙН ХИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ (ҮНДЭСНИЙ СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ)

Үүсгэн байгуулагдсан он - 1930

11

факультет

20

бакалаврын
чиглэл

14

магистрын чиглэл

8

специалитетын
чиглэл

14

аспирантурын
чиглэл

Тус их сургууль нь газрын тос, байгалийн хийн аж үйлдвэрийн бүхий л чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг: эрэл хайгуулаас эхлээд газрын тос ба байгалийн хийн олборлолт, тээвэрлэлт, боловсруулалт, технологийн үйл явцын техникийн болон мэдээллийн дэмжлэг үзүүлэх, газрын тос, байгалийн хийн зах зээлийн эдийн засаг, олон улсын талыг судлах хүртэл.

11 000



оюутан

2 200

гадаад оюутан

2

салбар


 Оренбург, Орос
 Ташкент, Узбекистан



Сургалтын жилийн төлбөр




358 000 - 415 000 RUB



 Их сургуулийн
тухай кино



Факультетуудын
нээлтэй хаалганы
өдөр

 www.gubkin.ru
 vk.com/gubkin.university
 t.me/gubkin_university



14
Инженер
техникийн
салбар



10
Ажил олгогчдын
эрэлтээр



23
Оросод
553
дэлхийд

 Орос, Москва

ЭЛСЭЛТИЙН КАМПАНИТ АЖИЛ

- Оросын Холбооны Улсын Засгийн Газрын квотын элсэгчид орос хэлний шалгалт өгнө
- Төлбөртэй суралцах элсэгчид математик, орос хэлний шалгалт өгнө

Элсэлтийн дүрэмд өөрчлөлт орж болно. gubkin.ru сайтын мэдээг анхаараарай.



Гадаадын иргэдийн элсэлт

Нээлттэй хаалганы өдрүүд жил тутам арван нэгдүгээр болон гуравдугаар сарын сүүлийн Ням гарагт явагддаг.

Их сургуулийн сайтаас цахимаар холбогдоорой www.gubkin.ru

ЭЛСЭЛТИЙН ШААРДЛАГА

Сургалтын хэл – орос хэл

Орос хэл сурах боломжууд

- их сургуулийн бэлтгэл ангид
- оршин сууж буй улсдаа ТРКИ тест авах цэгээс орос хэлний гэрчилгээ авах



ГАДААД ОЮУТНУУДАЙ АЖИЛЛАХ ХЭЛТЭС

**Хэлтсийн дарга
Александр Анатольевич Щербина**

+7 499 507-91-85

shcherbina.a@gubkin.ru

ЭЛСЭЛТИЙН КОМИСС

+7 499 507-80-42

+7 499 507-84-06

priem@gubkin.ru

hotline@gubkin.ru

ФАКУЛЬТЕТУУД

- Газрын тос, байгалийн хийн геологи, геофизик
- Газрын тос, байгалийн хийн орд олборлолт
- Дамжуулах хоолойн тээврийн системийн зураг төсөл боловсруулалт, бүтээн байгуулалт, ашиглалт
- Инженерийн механик
- Автоматик, тооцоолох техник
- Химийн технологи, экологи
- Эдийн засаг менежмент
- Олон улсын эрчим хүчний бизнес
- Хууль зүйн факультет
- Хүмүүнлэгийн боловсролын факультет



БЭЛТГЭЛ АНГИ

- **Бакалаврт элсэх**
орос хэл, математик, физик (хими), мэдээлэл зүй судлана
- **Магистр, аспирантурт элсэхэд**
орос хэл, дээд математик, мэдээлэл зүй судлана

Бэлтгэл ангийн төгсөгч төгсөлтийн шалгалтаа амжилттай өгсний дараа бакалавр/ специалитет/ магистр/ аспирантурын 1-р курст элсэх шалгалт өгөх эрхтэй болно.

Сургалтын хугацаа 1 жил

Сургалтын төлбөр **220 000 RUB**

Гадаад оюутнуудтай ажиллах хэлтэс

dis@gubkin.ru

ЭРЭЛТТЭЙ ЧИГЛЭЛҮҮД


- Газрын тос, байгалийн хийн мэргэжил
- Химийн технологи
- Эдийн засаг
- Менежмент
- Мэдээлэл зүй, тооцоолох техник



Дадлага хийж буй гадаад оюутнууд



Их сургуулийн газрын тос, байгалийн хийн объектуудтай танилцуулах аялал



Бие даасан бэлтгэл

ГАЗРЫН ТОС, БАЙГАЛИЙН ХИЙН МЭРГЭЖИЛ

бакалавр

- Газрын тос, байгалийн хийн цооногийн өрөмдлөг (өдрийн анги)
- Газрын тосны ашиглалтын байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ (өдрийн анги)
- Байгалийн хий, хийн конденсат, газар доорх агуулахын ашиглалт, засвар үйлчилгээ (өдрийн анги)
- Байгалийн хий, газрын тос дамжуулах хоолой, байгалийн хий, газрын тос хадгалах байгууламжийн бүтээн байгуулалт, засвар (өдрийн анги, өдрийн эчнээ хосолсон анги)
- Газрын тос, байгалийн хий болон боловсруулсан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ (өдрийн анги, өдрийн эчнээ хосолсон анги)

- ✓ Тэнхимийн лаборатори дахь туршилтын ажил
- ✓ Хуурай газар болон далайд цооног өрөмдөх үйл явцыг дуурайсан симулятор дээр ажиллах

Ажлын карьерын боломжууд


- Өрмийн мастер, инженер-технологич
- Менежер
- Өрмийн туслах, өрөмдлөгч, газрын тос, байгалийн хийн ашиглалт, цооногийн газар доорх засвар, бустер болон кластер шахуургын станц, ус, газрын тосны урьдчилсан цэвэрлэгээний төхөөрөмжийн оператор
- Газрын тос, байгалийн хий олборлогч байгууллагын үйлдвэрлэлийн бага дарга
- Зураг төсөл боловсруулах, инженерчлэл, судалгааны байгууллагуудын албан тушаал

Гадаад оюутнуудын ихэнх нь дэлхийн газрын тос, байгалийн хийн компаниудад эрэлттэй мэргэжилтнүүд болдог.

ХҮРЭЛЦЭН ИРЭХ

Нийслэл хотод ирсэн оюутнуудын тээвэр

 **Аэроэкспресс** – 470 RUB-ээс

 **Такси** – дунджаар 1 500 RUB

Хотын хамгийн тухай, хамгийн хурдан тээврийн хэрэгсэл бол метро юм. Нэг аялалын үнэ 50-75 RUB байдаг.

Их сургуульд очих нь хялбар байдаг тул ирсэн элсэгчдийг **Ленинский өргөн чөлөө, 65-р байр, 1** хаягаар их сургуульд хүлээн авдаг. «Академическая» метроны буудал.

Гадаадын иргэнийг хүрэлцэн ирэхэд визний бүрэн дэмжлэг үзүүлдэг. Эрүүл мэндийн даатгалыг элсэгч өөрийн зардлаар худалдаж авна.

Суралцахаар ирсэн гадаадын бүх иргэдийг их сургуулийн оюутны хотхон буюу нэг өрөөнд 2-3 хүний амьдардаг тохилог оюутны байранд байрлуулдаг. Байрны нэг жилийн төлбөр нь ойролцоогоор 20 000 RUB болдог.

Үндэсний соёлын долоо хоног – энэ бол их сургуулийн үндэстэн хоорондын харилцааг сайжруулахад чиглэсэн жил бүр зохион байгуулдаг арга хэмжээ юм. Хөтөлбөрт дэлхийн олон үндэстний өвөрмөц сонирхолтой зүйлсийг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэн, квест тоглоом, “Киноны нэрийг таа” тэмцээн, үндэсний хувцасны үзүүлбэр, дэлхийн олон ард түмнүүдийн хоол, гала концерт зэрэг багтдаг.

«Баатаруудын уралдаан»

**ОЮУТНЫ ХОТХОН**

- 5 оюутны байр, 4 000 гаруй ор
- Биеийн тамирын заал, цанын бааз, чөлөөт дасгалын талбай бүхий хөлбөмбөгийн талбай, сагсан бөмбөг, гар бөмбөгийн талбай
- Бүжиг, хөгжмийн зэмсэг, театрын студи, шатрын ба киноны клуб, урлагийн студи, дуу бичлэгийн студи

**ОЛОН ҮНДЭСТНИЙ НАЙРАМДЛЫН КЛУБ**

Олон нийтийн залуучуудын байгууллага нь оюутнуудыг Оросын ба гадаадын улс орнуудын олон ард түмний соёл, уран бүтээлтэй танилцуулдаг. Тус клуб нь их сургуульд байгуулагдсан 22 нийгэмлэгтэй хамтран ажилладаг. Хичээлийн жилийн эхэнд тэд элсэгчдийн дундаас "өөрсдийн" залуучуудыг олж, нэгдүгээр курсын оюутнуудад их сургууль болон Орост дасан зохицоход нь тусалдаг.





САНКТ-ПЕТЕРБУРГИЙН УЛСЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ИХ СУРГУУЛЬ

Үүсгэн байгуулагдсан он – 1808

4

факультет

23

тэнхим

3 000

оюутан ба
аспирант

Санкт-Петербургийн улсын мал эмнэлгийн их сургууль нь Оросын мал эмнэлгийн дээд боловсролын эх орон юм. 2023 оны 9-р сард тус их сургууль 215 нас хүрнэ.

3

диссертацийн
зөвлөл

30

мэргэжлийн
нэмэлт
боловсролын
хөтөлбөр

Өнөөдөр Санкт-Петербургийн улсын мал эмнэлгийн их сургууль нь улсын шилдэг гурван мал эмнэлгийн их сургуулийн тоонд багтдаг.



Нэг жилийн сургалтын төлбөр
Сургалтын бүх чиглэл – 270 000 RUB



spbguvm.ru

vk.com/officialspbguvm

📍 Орос, Санкт-Петербург

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Эрдэмтдийн удирдлаган дор тус их сургуульд 14 шинжлэх ухааны сургууль амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн 7 нь Оросын тэргүүлэх шинжлэх ухааны сургуулиудын бүртгэлийн жагсаалтад багтсан юм.

Олон жилийн эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааны үр дүнд тус их сургуульд 8 музей байгуулагдсан бөгөөд тэдгээрийн үзмэрүүд нь оюутнуудын онолын мэдлэгийг гүнзгийрүүлэх, бататгах гайхалтай үзүүлэн материал болдог юм.

Музейд амьтны аймгийн хамгийн том төлөөлөгчдөөс эхлээд хамгийн жижиг төлөөлөгч хүртэл анатомийн материалыг танилцуулсан байдаг. **Найман музейн нэг болох Эмгэг судлалын анатомийн музей нь дэлхийд тэргүүлэгчдийн нэг бөгөөд ЮНЕСКО-гийн хамгаалалтан дор байдаг.**

Их сургуулийн бүтцийн нэгжүүд дотор 234 000 ширхэг ном бүхий төв номын сан байдаг.

Оюутнууд практик мэргэжлийн ур чадварыг их сургуулийн мэс заслын, эмчилгээний, эх барих, эмэгтэйчүүдийн клиник эмнэлгүүдэд эзэмшдэг.



ОЛОН УЛСЫН БОЛОВСРОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

Тус хэлтсийн мэргэжилтнүүд элсэлт, сургалт, бэлтгэл ангийн үйл ажиллагааны талаархи бүх асуултанд хариулах болно. Мөн хувийн зөвлөгөө авах боломжтой.

☎ +7 905 814-01-20

☎ +7 812 388-93-76

✉ i@spbguvm.ru



БЭЛТГЭЛ АНГИ

Орос хэлний мэдлэггүй эсвэл муу мэдлэгтэй гадаадын иргэдийн хувьд.

Элсэлтийн нөхцөл:

- бүрэн дунд боловсрол, түүнийг батлах бичиг баримт (үнэмлэх, гэрчилгээ, диплом)
- орос хэл сурах хүсэл
- цаашид манай их сургуульд орос хэлээр дээд боловсрол эзэмших хүсэл

Анагаах ухаан, биологийн чиглэлийн боловсролын нэмэлт хөтөлбөрийн сургалт:

- орос хэл
- хими
- биологи
- физик

Зөвхөн өдрийн ангид суралцах боломжтой. Суралцах хугацаанд оюутны байраар хангана.

Өргөдөл хүлээн авах

- 2023 оны 5-р сарын 1-ээс 8-р сарын 31 хүртэл – суралцах зорилгоор ОХУ-ын нутаг дэвсгэрт байрлах виз шаардлагатай оюутнуудад
- 2023 оны 5-р сарын 1-ээс 9-р сарын 30 хүртэл – ОХУ-ын нутаг дэвсгэрт визгүй байрлах боломжтой оюутнуудад

Сургалтын хугацаа – 10 сар (2023 оны 10-р сарын 9-өөс 2024 оны 8-р сарын 9 хүртэл)

Сургалтын төлбөр – 140 000 RUB

специалитет, магистр

МАЛ ЭМНЭЛЭГ

Санкт-Петербургийн улсын мал эмнэлгийн их сургууль нь өнөөдөр улсын бараг бүх бүс нутаг, түүнчлэн бусад улс орны малын эмч бэлтгэх түүхэн үүргээ биелүүлж байна. Тус их сургууль нь Оросын баруун хойд бүс нутгийн малын эмч бэлтгэх боловсролын тэргүүлэх байгууллага юм.

Тус факультетад 3 000 орчим оюутан суралцдаг.

Сургалтын хэлбэр

- **специалитет:** өдрийн анги – 5 жил, өдрийн эчнээ хосолсон анги – 5,5 жил, эчнээ анги – 6 жил
- **магистр:** өдрийн анги – 2 жил

бакалавр, магистр

МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН ХЯНАЛТ

2003 оноос эхлэн мал эмнэлгийн хяналт, мал эмнэлгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, менежментийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх ажлыг явуулж байна. Эдгээр мэргэжилтнүүд амьтны болон ургамлын гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанарыг хариуцдаг.

Сургалтын хэлбэр

- **бакалавр:** өдрийн анги – 4 жил, өдрийн эчнээ хосолсон анги, эчнээ анги – 5 жил
- **магистр:** өдрийн анги – 2 жил

бакалавр, магистр

БИОЛОГИ

Санкт-Петербургийн улсын мал эмнэлгийн их сургуульд 2010 оны 7-р сард Биозкологийн сургалтын чиглэлийг нээсэн. Төгсөгчид экосистем ба биосферийн амьтны, ургамлын бүрэлдэхүүн хэсгүүдийн төлөв байдлыг судалж, үнэлж, эдгээр объектыг хамгаалж, норматив баримт бичгүүдийг боловсруулж, экспедицийн ажил ба лабораторийн судалгаа хийдэг.

Сургалтын хэлбэр

- **бакалавр:** өдрийн анги – 4 жил
- **магистр:** өдрийн анги – 2 жил

бакалавр, магистр

УСНЫ БИО НӨӨЦ, ЗАГАСНЫ АЖ АХУЙ

2010 онд оюутнуудын анхны элсэлтийг авч байсан. Төгсөгчдийн ирээдүйн мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлүүд: байгалийн болон хиймэл усан сангийн экосистем, гидробионтын хиймэл нөхөн үржүүлэх ба өсгөх технологийн үйл явц, загасны аж ахуйн байгууллагын тоног төхөөрөмж.

Сургалтын хэлбэр

- **бакалавр:** өдрийн анги – 4 жил
- **магистр:** өдрийн анги – 2 жил

ШИНЖЛЭХ УХААН

Их сургуулийн шинжлэх ухааны үйл ажиллагааны зохион байгуулалтыг шинжлэх ухааны хэлтэс хариуцдаг бөгөөд үүнд эрдэм шинжилгээний эмчилгээ-оношлогооны инновацийн төв багтдаг.

Тус төвд **жижиг гэрийн тэжээвэр амьтдын** клиник эмнэлэг багтдаг. Энд шинжлэх ухааны судалгаа, орчин үеийн арга барилын туршилт, мал эмнэлгийн салбарын хамгийн сүүлийн үеийн чиг хандлагыг боловсруулах ажил явагддаг.

Тус төвд бруцеллёз, сүрьеэ, кампилобактериоз судлалын лаборатори, протозооз судлалын лаборатори ба эмнэлзүйн биохимийн лаборатори тус тус багтдаг.



Санкт-Петербургийн улсын мал эмнэлгийн их сургууль нь Европын мал эмнэлгийн дээд боловсролын байгууллагуудын холбооны (EAEVE) гишүүн.

European Association of Establishments for Veterinary Education бол Европын мал эмнэлгийн мэргэжлийн боловсролын стандартын үйлчлэл ба түүнийг даган мөрдөлтийг зохицуулдаг Европын хамгийн том мал эмнэлгийн дээд байгууллагуудын төрийн бус холбоо юм.

СПУМЭИС-ИЙГ СОНГОХ ШАЛТГААН

- Олон зуун жилийн турш бий болсон мэргэжлийн мэдлэгийн суурь
- Мэргэжилтэн бэлтгэх чанар
- Сургалтын төлбөр бага
- Оросын хамгийн үзэсгэлэнтэй хотуудын нэгэнд суралцах боломж

Оюутны амьдрал бол зөвхөн хичээл биш. Тус их сургуульд оюутны зөвлөл ба оюутны мэргэжлийн холбоо идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэд их сургуулийн захиргаатай хамтран оюутнуудад зориулсан хичээлээс гадуурх арга хэмжээ зохион байгуулдаг: **аялалд явах, алдартай театрын тоглолт үзэх, Санкт-Петербург хотын хамгийн сонирхолтой музейд очих** гэх мэт.

Их сургуулийн оюутнууд биеийн тамир, бүжиг, театр, хөгжмийн тэмцээн уралдаанд идэвхтэй оролцдог.

Өөр хотоос ирсэн бүх оюутнуудыг оюутны байраар хангадаг.

Тус их сургуульд зөвхөн Оросын олон бүс нутгаас төдийгүй ойрын болон алс холын гадаадын улс орнуудын оюутнуудыг бэлтгэдэг: **Азербайжан, Беларусь, Грек, Гүрж, Израиль, Энэтхэг, Казахстан, Колумб, Киргиз, Латви, Ливан, Литва, Марокко, Молдав, Тажикистан, Узбекистан, Украин, Финлянд, Эстони**



ИХ ПЕТР ХААНЫ НЭРЭМЖИТ САНКТ-ПЕТЕРБУРГИЙН ПОЛИТЕХНИКИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Үүсгэн байгуулагдсан он – 1899

33 000+ оюутан	5 200 гадаад оюутан	280 000 төгсөгч
59 бакалавр бэлтгэх чиглэл	146 магистрын хөтөлбөр	77 аспирантурын чиглэл
25+ олон улсын хөтөлбөр	12 хүрээлэн	18 оюутны байр

СППУИС бол Оросын тэргүүлэгч техникийн их сургууль. Тус их сургууль нь орчин үеийн үйлдвэрлэлийн асуудлыг шийдвэрлэх ба бодит эдийн засгийн салбарт хурдан дасан зохицох чадвартай шинэ үеийн мэргэжилтнүүдийг бэлтгэх тогтолцоог бий болгож байна.

Нэг жилийн сургалтын төлбөр

Бакалавр 253 000 – 550 000 RUB

Специалитет 312 000 RUB

Магистр 269 000 – 598 000 RUB

Аспирантур 367 000 – 524 000 RUB







**200 АЖ ҮЙЛДВЭРИЙН ТҮНШ
БАЙГУУЛЛАГА**



Топ-3 Оросын их сургуулиудын дунд гадаад оюутны тоогоор

Топ-3 THE-ийн рейтингээр Оросын хамгийн олон үндэстний их сургуулиудын дунд (дэлхийж 139)



-  www.spbstu.ru
-  vk.com/international_polytech
-  t.me/polytech_eng
-  youtube.com/@spbpbu

📍 Орос, Санкт-Петербург

ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

- Барилга, эрчим хүчний хэмнэлт
- Эрчим хүч
- Математик загварчлал
- Ухаалаг систем, мэдээллийн технологи
- Компьютерийн инженерчлэл, дижитал үйлдвэрлэл
- Микро-нано цахилгаан технологи, харилцаа холбоо
- Техносферийн аюулгүй байдал
- Материал судлал, металлурги
- Шинэ материал, нэмэлт технологи
- Астрофизик, плазмын физик
- Био анагаах ухааны технологи
- Life science
- Эдийн засаг, бизнес, бизнес эрхлэлт



ЭЛСЭЛТИЙН КАМПАНИТ АЖИЛ

Бичиг баримт хүлээн авах, цахимаар

Орос руу визтэй нэвтрэх горимтой улсын иргэдийн хувьд **2-р сарын 20 – 8-р сарын 1**

Орос руу визгүй нэвтрэх горимтой улсын иргэдийн хувьд **2-р сарын 20 – 8-р сарын 15**

Элсэлтийн шалгалт, цахимаар

Элсэлтийн шалгалтын 6 үе шат **эхлэл – 4-р сар**

ЭЛСЭЛТИЙН КОМИСС Гадаадын иргэдэд

+7 812 606-62-41

interstudy@spbstu.ru



ЯАЖ ТӨСВИЙН ЗАРДЛААР СУРАЛЦАХААР ЭЛСЭХ ВЭ

- ОХУ-ын Засгийн Газрын квотоор (Россотрудничество)
- бакалавр, специалитет эсвэл магистрын хөтөлбөрийн сүүлийн курст суралцаж буй оюутнуудад зориулсан «Open Doors: Russian Scholarship project» Олон улсын олимпиадын үр дүнгээр



Education
in Russia



Open Doors

ИХ СУРГУУЛЬД ЭЛСЭХЭД БЭЛДЭХ ХӨТӨЛБӨРҮҮД

СППУИС-ийн бэлтгэл анги нь ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яамны гэрчилгээтэй.

- 3 чиглэл: инженерийн, эдийн засгийн, хүмүүнлэгийн – оюутны ирээдүйн мэргэжлийн чиглэлээс хамаарна
- Орос хэл сурах, мэргэжлийн хичээлийн мэдлэгээ системчлэж, дутуу мэдлэгээ нөхөх боломж
- Бичиг баримт хүлээн авах хугацаа **2-р сарын 20 – 10-р сарын 1**

Төлбөр
220 000 – 250 000 RUB



ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРҮҮД

 англи хэлээр

БАКАЛАВР БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРҮҮД

- Олон улсын бизнес
- Олон улсын худалдаа
- Дижитал байгууллагын эдийн засаг




ДАВУУ ТАЛУУД

- Сургалт олон улсын бүлгүүдэд бүхэлдээ англи хэлээр явагдана
- Гадаадын түнш их сургуульд суралцах боломж
- Тэтгэлэг авах боломж
- Дэлхийн чансаанд багтсан их дээд сургуулиудаар ирсэн СППУИС-ийн багш нар
- 200 томоохон түнш байгууллагуудад ажилд орох, шинжлэх ухаан ба бизнесийн дадлага хийх боломж
- Судалгаа хийхэд зориулагдсан дэлхийн түвшний шинжлэх ухааны лабораториуд

Оюутан бүрийн чанартай бөгөөд дээд зэрэглэлийн мэргэжлийн боловсрол нь СППУИС-ийн гол зорилго чиг үүрэг юм.

25+

англи хэлээр
явагдах
хөтөлбөрүүд 

МАГИСТР БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРҮҮД

Инженерийн чиглэлүүд

- Иргэний барилга
- Хот байгуулалтын хүрээлэн буй орчны инженерийн хамгаалалт
- Ослын бэлэн байдал, хариу арга хэмжээ
- Дулаан цахилгаан станц
- Цахилгаан эрчим хүч
- Цөмийн эрчим хүч
- Шинэ материал, нэмэлт технологи
- Лазерын болон шилэн кабелийн систем
- Мэдээлэл холбооны системийн микроэлектроник
- Механик, математик загварчлал
- Ухаалаг систем

Байгалийн шинжлэх ухаан

- Конденсат орчин ба функционал нано бүтцийн физик
- Молекул болон эсийн био анагаах ухааны технологи
- Плазмын физикийн хэрэглээний асуудлууд

Бизнес, эдийн засаг, менежмент

- Бизнес-инженерчлэл
- Технологийн манлайлал, бизнес эрхлэлт
- Олон улсын худалдааны харилцаа
- Олон улсын бизнесийн хөгжил
- Тоон санхүү

Хүмүүнлэгийн шинжлэх ухаан

- Бүс нутаг судлал: Оросын Холбооны Улс
- Дижитал хэл шинжлэл
- Дээд сургуульд гадаад хэл заах онол, практик
- Олон улсын салбарын зар сурталчилгаа, харилцаа холбоо



ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХОТХОН, ОРШИН СУУХ

170+

хичээлийн ба
шинжлэх ухааны
корпус

18

оюутны байр


4

метроны станц
алхаад очих зайд

- СППУИС-ийн бүх гадаад оюутнууд оюутны хотхоны олон улсын хэсэгт амьдардаг
- Оюутны байр нь хичээлийн байр, спортын төвтэй ойр байрладаг
- Бүх барилгууд нь видео хяналтын системээр тоноглогдсон бөгөөд цахим үнэмлэхээр нэвтэрдэг тул энэ нь бүх оюутнуудын аюулгүй байдлыг хангадаг
- Өдрийн ангийн оюутнуудыг блок хэлбэрийн оюутны байранд нэг өрөөнд 2-3 хүн **байрлах байраар хангана**. Блок дотор 2 унтлагын өрөө ба угаалгын өрөө байдаг. Бүх оюутны байранд орчин үеийн гал тогоо, угаалгын газар, хичээлийн өрөө, чөлөөт цагаа өнгөрөөх өрөө байдаг

Байрны нэг сарын төлбөр:

5 000 – 7 000 RUB, оюутны байрны тав тухын түвшнээс хамаарна



Элсэлтийн тухай
бүх мэдээлэл
(бичиг баримт,
хугацаа, жишээ
шалгалт)



Элсэлтийн хүсэлт



Гадаад иргэдийн
бүртгэл, визийн
дэмжлэг

СППУИС-Д ЭЛСЭХ 5 АЛХАМ

- 1 Сайтад «Элсэх хүсэлтийг» бөглөнө үү
- 2 Элсэлтийн шалгалтыг **online**-аар өгнө үү
- 3 Өргөдөл ба сургалтын гэрээнд гарын үсэг зурна уу
- 4 Сургалтын төлбөрийг **online**-аар хийнэ үү
- 5 Элсэлтийн тушаалын хуулбарыг хүлээн авна уу

Баяр хүргэе! Та албан ёсоор СППУИС-ийн оюутан боллоо!



Бүрэнтогтох Болормаа, Монгол Улс

Шинэ технологи бол гайхалтай зүйл, тиймээс би Санкт-Петербургийн Политехникийн их сургуульд наноэлектроникийн чиглэлээр суралцаж байна. Орос бол маш том, баялаг соёлтой орон учраас би Орос руу явахыг хүссэн. Санкт-Петербург хотыг би цаг уурын байдлаас нь болж сонгосон, ийм уур амьсгал надад таалагдсан. Энд маш нээлттэй хүмүүс амьдардаг! Политехникийн их сургуульд яг миний эзэмшихийг хүссэн мэргэжил байсан. Энд маш сайн багш нар ажилладаг, мөн орчин үеийн олон лаборатори, тоног төхөөрөмж байдаг. Хичээлийн бус цагаар би “Алтан намар” зэрэг наадамд очиж, эх орон нэгтнүүддээ дэмждэг. Миний гол зорилго шинжлэх ухаан хэдий ч би сайн дурын ажил хийж, бусад хүмүүст туслахыг хүсдэг. СППУИС-д суралцсан жилүүдэд би Оросоос гадна Шри Ланк, Хятад, Эстони улсаас ирсэн олон найзуудтай болсон.



ӨМНӨД УРАЛЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ (ҮНДЭСНИЙ СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ)

Үүсгэн байгуулагдсан он – 1943

250+

бакалавр ба
специалитетын
хөтөлбөр

150

магистрын
хөтөлбөр

82

аспирантурын
хөтөлбөр

Өмнөд Уралын улсын их сургууль нь Оросын дээд боловсролын манлайлагчдын нэг бөгөөд дижитал салбар, материал судлал ба экологийн чиглэлийн бүс нутгийн инновацийн хөгжлийн төв юм.

20

шинжлэх ухаан,
боловсролын төв

12

олон улсын
лаборатори

3

шинжлэх ухааны
хүрээлэн

Их сургуулийн давуу тал нь хүртээмжтэй үнэтэй чанартай боловсрол.

46

жижиг
инновацийн
байгууллага

25 000

оюутан

2 500

56 улсаас ирсэн
2 500 гадаад
оюутан

Нэг жилийн сургалтын төлбөр

≈ 1 500 – 2 500 USD*

*Ханш өөрчлөгдөж болно



susu.ru
олон хэлтэй сайт



vk.com/susu4you



801+



28

Оросын их дээд
сургуулиудын IT
салбарт



801+

ТОП-15

Оросын их дээд
сургуулиудын
дунд хамгийн их
эрэлттэй



801+



📍 Орос, Челябинск муж, Челябинск

ЭЛСЭЛТИЙН БИЧИГ БАРИМТ бакалавр ба магистрын хөтөлбөр

- Гадаад паспорт
- Өмнөх боловсролын бичиг баримт
- Бичиг баримтуудын орос хэлний орчуулга

Элсэлтийн шалгалт нь тест эсвэл хувийн ярилцлага хэлбэрээр явагдана

Гадаадын иргэдэд

- Визийн дэмжлэг – үнэ төлбөргүй
- Бичиг баримт бүрдүүлэлт – үнэ төлбөргүй
- Нисэх онгоцны буудалд тосох – үнэ төлбөргүй
- Оюутны байраар баталгаатай хангана, сарын төлбөр ≈ 20 USD

Заавал! Оросын их сургуульд элссэний дараа

- Эрүүл мэндийн үзлэг ≈ жилийн 75 USD
- Эрүүл мэндийн баталгаажуулалт ≈ 100 USD нэг удаа

ЯАЖ ЭЛСЭХ ВЭ?

- 1 Бичиг баримтаа ✉ applicant@susu имэйл руу илгээнэ үү
- 2 Анкетыг бөглөж, сургалтын гэрээний төлбөрийг хийнэ үү
- 3 Нэвтрэх урилга хүлээн авна уу

ГАДААД ОЮУТНУУДАЙ АЖИЛЛАХ ХЭЛТЭС

- ☎ +7 902 607-99-64
WhatsApp, Telegram
- ☎ +7 351 272-30-86
- ✉ applicant@susu.ru



ЭЛСЭЛТ

Сургалтыг **орос** 🇷🇺, **англи хэлээр** 🇬🇧 явуулна

Орос хэлтэй хөтөлбөрүүдээр суралцахын тулд гадаадын иргэд нэг жилийн турш жилийн бэлтгэл ангид хамрагдах боломжтой – ӨУРУИС-ийн бэлтгэл ангид орос хэл сурч, тусгай хичээлүүдийг орос хэлээр судлах боломжтой.



ГАДААДЫН ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БЭЛТГЭЛ АНГИ

Орос хэлийг гадаад хэлээр судлах ба мэргэжлийн хичээлийн анги

Хэлийг А0 түвшнээс эхлэн сурах

Хичээлүүд

- Техникийн шинжлэх ухаан – инженерчлэл, мэдээллийн технологи, автомашин үйлдвэрлэл, иргэний барилга бүтээн байгуулалт, архитектур
- Хүмүүнлэгийн шинжлэх ухаан – хууль зүй, түүх, хэл судлал, сэтгэл судлал
- Анагаах ухаан – спорт, эрүүл мэндийн салбарын судалгаа
- Эдийн засгийн шинжлэх ухаан – эдийн засаг, менежмент, маркетинг, бизнесийн удирдлага, эконометрик
- Байгалийн шинжлэх ухаан – биологи, физик, хими, нанотехнологи

Сургалтын төлбөр 99 000 RUB ≈ 1 100 USD (ханш өөрчлөгдөж болно)

ЭРЭЛТЭЙ ХӨТӨЛБӨРҮҮД

англи хэлтэй 

Бакалавр, 4 жил

- Суурь мэдээлэл зүй, мэдээллийн технологи
- Мехатроник, робот техник
- Бүтээгдэхүүний технологи, нийтийн хоолны зохион байгуулалт
- Олон улсын эдийн засаг, худалдаа

Магистр, 2 жил

- Математик. Тухайн уламжлалын тэгшитгэл
- Хэрэглээний математик, физик. Хүний бие организмд шаардлагатай биофотоник ба физик аргууд
- Хүрээлэн буй орчны инженерийн хамгааллын үйл ажиллагааны химийн бодисууд
- Барилга бүтээн байгуулалт. Архитектур, барилгын салбарын цахимжуулалт
- Дулааны эрчим хүч, дулааны техник
- Цахилгаан эрчим хүч, цахилгааны техник
- Машин үйлдвэрлэл. Гагнуурын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, технологи
- Технологич машин, тоног төхөөрөмж. Гидравлик, вакуум, шахалтын технологи
- Мехатроник, робот техник
- Биотехнологи. Аж үйлдвэрийн болон байгаль орчны биотехнологи
- Эдийн засаг. Олон улсын бизнес
- Менежмент. Стратегийн болон инновацийн маркетинг
- Санхүү, зээл. Санхүүгийн зах зээл ба институтууд
- Хууль зүй. Хууль зүй ба дижитал технологи
- Сэтгүүл зүй. Хэвлэл мэдээллийн харилцаа холбоо
- Филологи. Англи хэлний онол практик

Гадаадын иргэд Оросын Засгийн Газрын **ТЭТГЭЛЭГ** авах боломжтой.

Яаж гэж үү? Бидэнтэй холбогдоод мэдэж аваарай!



Шинжлэх ухааны лабораторид



Хүнсний орц найрлагын нийлэгжилт, шинжилгээний лаборатори



Шилдэг оюутнууд

АЖИЛ ОЛГОГЧ ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД

Касперскийн лаборатори, Сбербанк, Магнитогорскийн металлургийн үйлдвэр, КАМАЗ, «Роскосмос», «Росатом» улсын корпорацууд болон бусад байгууллагууд.



kaspersky



РОСКОСМОС



KAMAZ





Оюутны хотхон – Оросын хамгийн том, шилдэгүүдийн нэг. Оюутны байрны барилгууд нь хичээлийн байрнаас алхаад очих зайд байрладаг. Оюутны хотхон нь Челябинск хотын төвд байрладаг бөгөөд 9 оюутны байртай. Хажууд нь өргөн уудам ой модны бүс байрладаг – соёл, амралтын хүрээлэн, оюутны эмнэлэг, бассейн, биеийн тамирын заал, худалдааны төв.

БҮТЭЦ

- Архитектур, барилгын хүрээлэн
- Анагаах ухаан, биологийн сургууль
- Эдийн засаг, удирдлагын дээд сургууль
- Электроник, компьютерийн шинжлэх ухааны дээд сургууль
- Хэл зохиол, олон улсын харилцааны хүрээлэн
- Хэвлэл мэдээлэл, нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны хүрээлэн
- Байгалийн ба хийсвэр шинжлэх ухааны хүрээлэн
- Спорт, аялал жуулчлал, үйлчилгээний хүрээлэн
- Политехникийн хүрээлэн
- Хууль зүйн хүрээлэн



Александр Вагнер, ӨУРУИС-ийн ректор

Өнөөдөр Өмнөд Уралын улсын их сургууль нь Оросын орчин үеийн боловсролын манлайлагчдын нэг болсон! Бид их сургуулийн түүх, уламжлалаа дээдлэн хүндлэж, цаг үеийн сорилтод нийцүүлэн хөгжиж байна.



Нардина Абилбат, Монгол Улс

Энэ бол оюутан насанд минь миний хоёр дахь гэр болж, Монголд ажлын карьерыг хангах боловсролыг олгосон их сургууль юм.

AISA

Өмнөд Уралын гадаад оюутнууд ба төгсөгчдийн холбоо нь тухайн бүс нутгийн хамгийн том гадаад сурагчдын холбоо юм.

Энэ бол Челябинск мужийн их сургуулийг сонгосон хүмүүсийн нөхөрлөл, харилцан туслалцаа, дэмжлэгийн баг юм!

Бидэнтэй нэгдээрэй







Оросын боловсролын тухай
анхны олон хэлтэй сэтгүүл

hedclub.com



АДАПТАЦИЯ
ИНОСТРАННОГО СТУДЕНТА
В РОССИИ И ВУЗЕ

**CHOOSING
A CAREER FOR
A SUCCESSFUL
FUTURE**

**МОНГОЛЫН
ЗӨРМӨЛСӨН ОРОСЫН
БОЛОВСРОЛ**

**NÊN GI
DỤC**

**Niveaux
supé**

Higher Education Discovery

Олон хэлтэй сэтгүүл

гадаадын элсэгчдэд



Ойлгомжтой хэлээр унш
hedclub.com

